



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 15 (540)

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 03 дугаар дүгнэлтийн тухай*

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- *Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай*
- *Монгол Улсын сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2008 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2008 оны дөрөвдүгээр сарын 21

№15 (540)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

199.	Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 03 дугаар дүгнэлтийн тухай	Дугаар 20	346
200.	Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай	Дугаар 21	346
201.	Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай	Дугаар 22	346

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

202.	Журам батлах тухай	Дугаар 359	346
203.	Хөтөлбөр батлах тухай	Дугаар 07	353

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

204.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8.1.4, 8.1.5 дахь заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрсөн эсэх маргааныг шийдвэрлэсэн тухай	Дугаар 04	356
------	---	-----------	-----

### Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

205.	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг шүүхийн практикт хэрэглэх тухай	Дугаар 10	359
206.	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай	Дугаар 11	361
207.	Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай	Дугаар 12	362
208.	Эрүүгийн хуулийн 146 дугаар зүйлд заасан "Бусдын эд хөрөнгийг булаах" гэмт хэргийг 147 дугаар зүйлд заасан "Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх" гэмт хэргээс ялгаж, зөв зүйлчлэхэд анхаарах зарим асуудлын талаар	Дугаар 13	364
209.	Эрүүгийн хуулийн 93 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах, санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчдсан үед бусдыг санаатай алах гэмт хэргийг хүнийг санаатай алах гэмт хэргээс ялгаж, зөв зүйлчлэх талаар	Дугаар 14	365
210.	Газрын тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай	Дугаар 15	366
211.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай	Дугаар 16	367
212.	Монгол Улсын сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай	Дугаар 17	372

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

### Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 03 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын ерөнхий прокуророос Улсын Их Хуралд оруулсан саналыг хэлэлцсэн тухай Улсын Их Хурлын 2007 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 102 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Хорин есдүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийг тус тус зөрчсөн байна

гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдөр буюу 2008 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

### Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын ерөнхий прокуророос Улсын Их Хуралд оруулсан саналыг хэлэлцсэн тухай Улсын Их Хурлын 2007 оны 12 дугаар сарын 28-

ны өдрийн 102 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс буюу 2008 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

### Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3-ыг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8.1.4 дэх заалт, мөн хуулийн 8.1.5-ын "энэ хуулийн 8.1.4-г зааснаас бусад" гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Гуравдугаар зүйлийн 1, Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус

зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдөр буюу 2008 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 12 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 359

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 6.1.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг

тодорхойлох, тодотгол хийх журмыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаад үүрэг болгох нь:

а/ Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн 2011-2015 оны тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох арга хэмжээг 2008 онд багтаан авч хэрэгжүүлсүгэй;

б/ Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалтад 4 жил тутам энэхүү журмын дагуу тодотгол хийж, Засгийн газраар батлуулан хэрэгжилтийг нь зохион байгуулж байсугай.

3. Эрхлэх ажлынхаа хүрээнд шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийг 2008 онд багтаан тодорхойлж, түүнд 4 жил тутам тодотгол хийж хэрэгжүүлэх арга хэмжээ авч байхыг сайд нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАЯР**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД . Н.БОЛОРМАА**  
Засгийн газрын 2007 оны 359 дүгээр  
тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ЦӨМ ТЕХНОЛОГИЙГ ТОДОРХОЙЛОХ, ТОДОТГОЛ ХИЙХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг зүйл

1.1. Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл (цаашид "Тэргүүлэх чиглэл" гэнэ), цөм технологи (цаашид "Цөм технологи" гэнэ)-ийг тодорхойлох, тэдгээрт тодотгол хийх ажлыг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхой үе шаттайгаар тодотгож байх нь шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын салшгүй хэсэг болно. Улсын Их Хурлын 1998 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан "Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого"-ын 2.1.5-д "шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх ... тэргүүлэх чиглэлүүдийг эдийн засаг, нийгмийн хөгжлийн тодорхой үе шатны зорилттой уялдуулан байнга өөрчлөн тодотгож байх...", Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 6.1.2-т "шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тодорхойлон батлах" гэж заасан нь шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлон хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл болно.

1.3. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хурдасгах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, өндөр технологийг нутагшуулах, хөгжүүлэх, технологийн аюулгүй байдлыг хангах зорилготой шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг уялдуулан тодорхойлж хэрэгжүүлэх нь эрдэм шинжилгээний ажлыг нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилтод нийцүүлэх, түүнд зарцуулж байгаа төсвийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх нэг чухал хөшүүрэг мөн.

1.4. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлж байх нь шинжлэх ухаан, технологийн зорилтот хөтөлбөр, онцгой ач холбогдол бүхий инновацийн төсөл боловсруулж хэрэгжүүлэх үндсийг бүрдүүлнэ.

1.5. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох, тэдгээрт тодотгол хийх ажлыг 4 жил тутамд гүйцэтгэнэ.

### Хоёр. Нэр томъёо

Энэхүү журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1. "Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл" гэж технологийн бааз, шинжлэх ухааны багтаамж ихтэй үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх үндсэн дээр эдийн засгийн өсөлтийг хурдасгах, аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, үндэсний болон технологийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах, аль нэг салбарын болон салбар дундын ач холбогдолтой шинжлэх ухаан, технологийн сэдэвчилсэн чиглэлийг;

2.2. "Монгол Улсын цөм технологи" гэж тэргүүлэх чиглэлийн хүрээнд тодорхойлсон сэдэвчилсэн чиглэлийг хэрэгжүүлэх нөхцөлийг хангахуйц, эдийн засгийн төрөл бүрийн салбарт инновацийн шинэ ололтыг нэвтрүүлэх өргөн боломжтой, тухайн тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд хамгийн их хувь нэмэр оруулах салбар дундын шинжтэй технологийн шийдлийн цогцыг.

### Гурав. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох ажлын үе шат

3.1. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох, тэдгээрт тодотгол хийх ажлыг дор дурдсан үе шатаар гүйцэтгэнэ:

3.1.1. Зохицуулах зөвлөл байгуулах;

3.1.2. шинжээчдийн баг бүрдүүлэх;

3.1.3. салгуур үзүүлэлтийг тодорхойлох;

3.1.4. мэдээллийн бааз бүрдүүлэх;

3.1.5. тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох үйл ажиллагаа явуулах;

3.1.6. тэргүүлэх чиглэл, цөм технологийг хэлэлцүүлж баталгаажуулах.

### Дөрөв. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох үйл ажиллагааг зохион байгуулах

4.1. Зохицуулах зөвлөл, гүйцэтгэгч-байгууллага

4.1.1. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох ажлын бүх үе шатыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор шийдвэрлэх асуудлын хүрээг тодорхойлох, үг ажлын гүйцэтгэгч, оролцогчдыг сонгох, зохион байгуулалтын орчинг бүрдүүлэх арга хэмжээ авна. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох, тэдгээрт тодотгол хийх ажлыг арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, яам, бусад байгууллагатай зохицуулалт хийх, ажлын үр дүнг эрх бүхий байгууллагод өргөн барих үүрэг бүхий Зохицуулах зөвлөлийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулна.

4.1.2. Зохицуулах зөвлөлийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн удирдана. Зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнд шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, холбогдох яам, агентлаг, Шинжлэх ухааны академи, Шинжлэх ухаан, технологийн сан, эрдэм шинжилгээний байгууллага, их сургууль, аж үйлдвэрийн холбоод, томоохон компанийн төлөөллийг оруулна.

4.1.3. Зохицуулах зөвлөл дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.3.1. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох үйл ажиллагаа, гүйцэтгэгч, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах нөөц, хүлээгдэж байгаа үр дүнг багтаасан зохион байгуулалтын ажлын төлөвлөгөө боловсруулах;

4.1.3.2. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох гүйцэтгэгч-байгууллага, шинжээчдийг томлох, тэдгээрийн үүрэг, хүлээх хариуцлагын хүрээг тогтоох;

4.1.3.3. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох үе шат, түүнд татан оролцуулах хүний болон бусад нөөцийг тогтоох;

4.1.3.4. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийг гаргах;

4.1.3.5. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг хэрэгжүүлэх санал боловсруулах;

4.1.3.6. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох ажлыг гүйцэтгэхэд шаардагдах санхүүжилтийн хэмжээг тодорхойлох;

4.1.3.7. Тэргүүлэх чиглэл бүрээр шинжээчдийн баг бүрдүүлэх;

4.1.3.8. Тэргүүлэх чиглэл, цөм технологийн саналыг дүгнэлтийн хамт шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагод хүлээлгэн өгөх.

4.1.4. Дордурдсан үүрэг бүхий гүйцэтгэгч-байгууллагыг Зохицуулах зөвлөлийн шийдвэрээр томилно.

4.1.4.1. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлоход шаардлагатай мэдээлэл бүрдүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний болон үйлдвэр, аж ахуйн

байгууллага, эрдэмтэн, судлаачдын дунд санал асуулга явуулах.

4.1.4.2. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлоход шаардагдах инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт, тэдгээрийн үндсэн шинж чанарын тодорхойлолтыг бэлтгэх;

4.1.4.3. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлоход шаардагдах мэдээллийн бааз бүрдүүлэх, бусад анхдагч материал бэлтгэх, арга зүйн баримт бичгийг боловсруулах;

4.1.4.4. Тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалтын төсөл бэлтгэх;

4.1.4.5. Тухайн үед шаардагдах бусад асуудлыг зохион байгуулах.

## 4.2. Шинжээчдийн баг бүрдүүлэх

4.2.1. Дор дурдсан үүрэг бүхий шинжээчдийн багийг гүйцэтгэгч-байгууллагын саналыг үндэслэн Зохицуулах зөвлөлийн шийдвэрээр байгуулна:

-Гүйцэтгэгч-байгууллагын явуулсан судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийх;

-Тэргүүлэх чиглэл, цөм технологийн томъёоллыг нарийвчлах санал боловсруулах;

-Инновацийн бүтээгдэхүүний үнэлэх;

-Цөм технологийн карт бүрдүүлэх;

-Тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх арга хэмжээний саналд дүн шинжилгээ хийх.

4.2.2. Шинжээчдийн багийн бүрэлдэхүүнд яам, агентлаг болон Шинжлэх ухааны академи, эрдэм шинжилгээний байгууллага, их сургууль, үйлдвэрийн газрын эрдэмтэн, тэргүүлэх мэргэжилтнийг оруулна.

4.3. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох шалгуур үзүүлэлт

4.3.1. Тэргүүлэх чиглэлийг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн стратегийн дараахь зорилтуудтай нягт уялдаатай сонгоно;

4.3.1.1. үндэсний эдийн засгийн хөгжлийн тогтвортой өндөр хурдыг хангах;

4.3.1.2. хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, хүний хөгжилд дэмжлэг үзүүлэх;

4.3.1.3. хүн амын эрүүл мэнд, амьдралын нөхцөлийг сайжруулах;

4.3.1.4. эдийн засгийн өсөлтийн салбарын бүтцийн хязгаарлалтыг арилгах;

4.3.1.5. үндэсний аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, дотоод, гадаадын зах зээлд байр суурийг нь бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.3.1.6. Монгол Улсын бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэтгэх;

4.3.1.7. дэлхийн эдийн засагт Монгол Улсын зохистой интеграцчиллыг хөгжүүлэх;

4.3.1.8. экологийн тэнцвэрт байдлыг хангах.

4.3.2. Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн дээр дурдсан стратегийн зорилтуудын хүрээнд Тэргүүлэх чиглэлийг тодорхойлохдоо дараахь шалгуур үзүүлэлтийг ашиглана:

Шалгуур үзүүлэлт 1. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг хурдасгах, түүний бүтцийг сайжруулах, үндэсний эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд тухайн тэргүүлэх чиглэлийн оруулах хувь нэмэр. Үүнийг дараахь үзүүлэлтээр тодорхойлно:

-дотоод, гадаадын зах зээлд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар (гадаадын адил төстэй бүтээгдэхүүний чанарын болон бусад үзүүлэлттэй харьцуулсан дүн; технологийн түвшин, агууламж, нэмүү өртөг бүтээх боломж, үйлдвэрлэлийн зах зээлд нэвтрэх саад бэрхшээл гэх мэт);

-цөм технологийг ашиглан бий болгосон бүтээгдэхүүний дотоод, гадаадын зах зээлийн борлуулалтын одоогийн болон цаашдын боломжит хэмжээ, тэдгээрийн үзүүлэлт (тогтвортой байдал, өсөлтийн хурдац гэх мэт);

-дотоод, гадаадын зах зээл дэх борлуулалтын хүлээгдэж байгаа өсөлт.

Шалгуур үзүүлэлт 2. Монгол Улсын үндэсний болон технологийн аюулгүй байдлыг хангахад тухайн Тэргүүлэх чиглэлийн оруулах хувь нэмэр. Үүнийг дараахь үзүүлэлтээр тодорхойлно:

-нэн шаардлагатай бүтээгдэхүүн, технологийн импортын хамаарлыг даван туулахад үзүүлэх нөлөө;

-учирч болзошгүй техногенийн аюул, эрсдэл (үнийн болон технологийн үзүүлэлтээр)-ийг бууруулахад оруулах хувь нэмэр.

Шалгуур үзүүлэлт 3. Оюуны багтаамжийн үзүүлэлт:

-шинэ бүтээлийн түвшинд хийгдсэн технологийн тооны өсөлт;

-нийт боловсруулсан технологийн дотор дэлхийн тэргүүний түвшинд хүрсэн үзүүлэлттэй технологийн эзлэх хувийн жингийн өсөлт.

4.3.3 Тэргүүлэх чиглэл тус бүрийн хүрээнд хөгжүүлэх цөм технологийг тодорхойлохдоо дараахь шалгуур үзүүлэлтийг ашиглана:

Шалгуур үзүүлэлт 1. Үйлдвэрлэл, үйлчилгээний аль болох олон салбарт өргөн ашиглах болон шинэ хэрэгцээ, хэрэглээг үүсгэх боломж

Шалгуур үзүүлэлт 2. Үндэсний хөгжлийн цогц бодлогын зорилтууд, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэхэд оруулах хувь нэмэр.

Шалгуур үзүүлэлт 3. Засгийн газраас хэрэгжүүлж байгаа шинжлэх ухаан, технологийн болон бусад хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх боломж.

4.3.4. Цөм технологийг сонгохдоо энэ журмын 4.3.3-т дурдсан шалгуур үзүүлэлтээс гадна тухайн технологийн хэрэглээний дор дурдсан нөхцөлийг харгалзан үзнэ:

-боломжит хэрэглэгчийн өсөлт;  
-технологийн шийдлийн үзүүлэлт;  
-боловсруулалтын түвшин, зэрэг;  
-бэлтгэгдсэн боловсон хүчний нөөц;  
-үйлдвэрлэлийн баазын байдал, төлөв;  
-үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд шаардагддаг хөрөнгө оруулалтын хэмжээ;  
-эрсдэлийн үнэлгээ.

4.3.5. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг сонгохдоо зөвхөн нэг салбарын шинжтэй чиглэл, технологийг оруулахаас аль болох зайлсхийж санхүүгийн нөөцийг үр ашигтай зарцуулах, технологийн салбар дундын ашиглалтын боломж, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулах, байгаль орчны бохирдлыг бууруулахад оруулах хувь нэмрийг харгалзан хамгийн цөөн тоотой байх зарчим баримтална. Тэргүүлэх чиглэл, цөм технологийн томъёолол нь маш оновчтой, товч тодорхой байна.

4.4. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлоход ашиглах мэдээллийн бааз бүрдүүлэх

4.4.1. Тэргүүлэх чиглэл болон цөм технологийг тодорхойлох, тэдгээрийг тодотгоход дараахь мэдээллийн баазыг бүрдүүлж ашиглана:

4.4.1.1. мөрдөж байгаа тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалт;

4.4.1.2. төрийн захиргааны төв байгууллага, Шинжлэх ухааны академ, эрдэм шинжилгээний байгууллага, их сургууль, мэргэжлийн байгууллага, холбоодоос ирүүлсэн тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодотгох тухай санал;

4.4.1.3. инновацийн ирээдүйтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ болон тэдгээрийн үйлдвэрлэлд зайлшгүй шаардлагатай технологийн талаар гүйцэтгэгч байгууллагаас явуулсан санал асуулгын нэгдсэн дүн;

4.4.1.4. шинжлэх ухаан, технологийн болон нийгэм, эдийн засгийн хөгжлийг прогнознолох, цөм технологийг сонгох талаар хийсэн дотоод, гадаадын судалгаа шинжилгээний ажлын үр дүн;

4.4.1.5. шинжлэх ухааны тухайн салбарт хэрэгжүүлж байгаа судалгаа, боловсруулалтын ажлын түвшин, олон улсын

түвшинд Монголын шинжлэх ухааны эзлэх байр суурь.

4.4.1.6. Монголын эрдэмтдийн хэвлүүлсэн бүтээл, түүний ишлэл, олон улсын хамтын ажиллагааны талаархи ном зүйн дүн шинжилгээ.

4.5. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох үйл ажиллагаа

4.5.1. Шинжээчдийн санал асуулга явуулах

4.5.1.1. Цөм технологийн үндсэн дээр үйлдвэрлэж болох ирээдүй бүхий инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг бий болгоход шийдвэрлэх ач холбогдолтой технологийн талаар цуглуулсан мэдээллийг баяжуулах зорилгоор шинжээчдийн дунд санал асуулга явуулна (Энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар баталсан маягтын дагуу явуулна).

4.5.1.2. Санал асуулгаар гүйцэтгэгч-байгууллагын бэлтгэсэн инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтад үнэлгээ, дүгнэлт гаргаж, шинжээчид мэргэжлийн чиглэлээр онцгой чухал гэж үзсэн гадаадын тэргүүний технологийн ололт болон үндэсний шинжлэх ухаан, технологийн зөхцөйг ашиглан ойрын 10 жилд үйлдвэрлэх боломжтой инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэрлэж, тэдгээрийг үйлдвэрлэхэд шийдвэрлэх үүрэгтэй технологийн жагсаалтыг бэлтгэсэн маягтын дагуу гаргана (журмын 1 дүгээр хавсралт).

4.5.1.3. Санал асуулга явуулахдаа журмын 4.3.3, 4.3.4-т заасан шалгуур үзүүлэлт, нөхцөлийг баримтална.

4.5.1.4. Санал асуулгын дүнг шинжээчдийн багууд бүлэглэн нэгтгэн боловсруулж давхардлыг арилгана. Энэ үндсэн дээр тэргүүлэх чиглэл, цөм технологи, тэдгээрийг ашиглан бий болгох бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн жагсаалтыг гаргана. Энэ жагсаалт нь тэргүүлэх чиглэл бүрийн үйлдвэрлэл, технологийн бүхий л үндсэн чиглэлийг багтаасан бүтээгдэхүүн, үйлчилгээний үндсэн бүлгүүдийг хамарсан цөөн тоотой байна.

4.5.2. Бүлгийн хэлэлцүүлэг зохион байгуулах

4.5.2.1. Энэ журмын 4.5.1.4-т заасан жагсаалтыг шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл тус бүрээр байгуулсан өндөр мэргэшлийн, нэр хүнд бүхий шинжээчдээс бүрдсэн бүлгүүдээр хэлэлцүүлнэ.

4.5.2.2. Бүлэг нь цөм технологийг ашигласнаар бий болох инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үзүүлэлтүүдийг энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан маягтын дагуу үнэлж уг цөм технологийн инновацийн чадавхийг илрүүлнэ. Инновацийн бүтээгдэхүүнийг үнэлэхэд 4.3.3, 4.3.4-т заасан шалгуур үзүүлэлт, нөхцөлийг ашиглана.

4.5.2.3. Бүлгийн хэлэлцүүлгээр чухал ач холбогдолтой инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт, тэдгээрийн үйлдвэрлэлд зайлшгүй шаардлагатай технологийн жагсаалт, тэргүүлэх чиглэл, цөм технологид оруулах нэмэлт, өөрчлөлтийн санал гаргана.

4.5.2.4. Бүлгийн хэлэлцүүлгээр энэ журмын 4.5.2.3-т заасан бичиг баримтыг бэлтгэсний дараа цөм технологийн инновацийн чадавхийг үнэлэхэд ашиглах "Цөм технологийн карт"-ыг энэхүү журмын 3 дугаар хавсралтаар баталсан маягтын дагуу бэлтгэнэ.

4.5.3. Тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалтыг эцэслэн боловсруулах, баталгаажуулах

4.5.3.1. Бүлгийн хэлэлцүүлгийн ажлын үр дүнд сонгосон тэргүүлэх чиглэлийн жагсаалт, цөм технологийн томъёолол, тэдгээрийн хүрээнд бий болгох бүтээгдэхүүн, үйлчилгээний үзүүлэлтийг үнэлэх, онц чухал ач холбогдолтой инновацийн бүтээгдэхүүний жагсаалтад нэмэлт оруулах зорилгоор шинжээчдээр хянан магдалгаа хийлгэнэ.

4.5.3.2. Хянан магдалгаа хийсэн шинжээчид бүлгийн хэлэлцүүлгээр бэлтгэсэн чухал ач холбогдолтой инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний болон тэдгээрийн үйлдвэрлэлд зайлшгүй шаардлагатай технологийн жагсаалт, тэргүүлэх чиглэл, цөм технологийн төсөлд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналаа нэгтгэн боловсруулж Зохицуулах зөвлөлд ирүүлнэ.

4.5.3.3. Зохицуулах зөвлөл нь энэ журмын 4.5.3.2-т заасан саналыг хүлээн авч тэргүүлэх чиглэл, цөм технологийн бүтцийн тухай санал, цөм технологийн картууд, онц чухал инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт, шинжлэх ухаан, технологийн зорилтот хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлэх инновацийн төсөл, арга хэмжээний санал зэргийг эцэслэн боловсруулж, шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад илгээжүүлнэ.

4.5.3.4. Шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага сонгосон тэргүүлэх чиглэл, цөм технологид нэгдсэн үнэлгээ хийх, эцсийн жагсаалтад орхигдсон болон шинээр үүсэн хөгжиж байгаа онцгой чухал, шинэ чиглэлүүдийг илрүүлэх зорилгоор бусад яам, Шинжлэх ухааны академи, их сургуулиуд, мэргэжлийн холбоодын саналыг авч эцэслэн боловсруулна.

4.5.3.5. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох, тэдгээрт тодотгол хийх ажлын үр дүнд дор дурдсан бичиг баримтын эцсийн хувилбар гарна.

-Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл,

-Цөм технологийн тодотгосон жагсаалт.

-Онц чухал ач холбогдолтой инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт;  
-Цөм технологийн картууд.

4.5.3.6. Шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 4.5.3.5-д дурдсан баримт бичгийг Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулна.

4.5.3.7. Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалтыг Монгол Улсын Засгийн газар батална.

4.6. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг хэрэгжүүлэх арга хэмжээ

4.6.1. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц хөрөнгө, эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээг шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага холбогдох яам, Засгийн газрын агентлагтай хамтран тодорхойлж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

4.6.2. Энэ журмын 4.3.1-д заасан улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн стратегийн зорилтуудад нийцэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлгүүдээр инновацийн хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлнэ.

4.6.3. Бүтээгдэхүүн, үйлчилгээний бусад бүлгээр гэдгээрийн практик хэрэгжилтэд зайлшгүй шаардлагатай технологийн жагсаалт гаргаж, түүнийг төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төслийн хүрээнд боловсруулах арга хэмжээ авна.

## Дөрөв.Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох ажлын санхүүжилт

4.1. Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох, гэдгээрт тодотгол хийх үйл ажиллагааг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тухайн жилийн төсвийн багцад тусган санхүүжүүлнэ.

## Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох, тодотгол хийх журмын 1 дүгээр хавсралт

### МОНГОЛ УЛСЫН ЦӨМ ТЕХНОЛОГИЙН ЖАГСААЛТАД ТОДОТГОЛ ХИЙХ САНАЛ АСУУЛГЫН МАЯГТ

Төрийн байгууллага, Шинжлэх ухааны академи, эрдэм шинжилгээний байгууллага, их сургууль, аж үйлдвэрийн салбарын нэгж, мэргэжлийн холбоодын төлөөлөл оролцоно.

Яам, байгууллагын нэр: \_\_\_\_\_

Тэргүүлэх чиглэлийн нэр: \_\_\_\_\_

Онц чухал инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи

№	Инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, түүний үндсэн шинж чанар	Бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоход шийдвэрлэх ач холбогдолтой технологи

Албан тушаал

Овог, нэр



Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох, тодотгол хийх журмын 2 дугаар хавсралт

## БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ИННОВАЦИЙН ЧАДАВХИЙГ ҮНЭЛЭХ ҮЛГЭРЧИЛСЭН МАЯГТ

Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэлгээ, түүний үйлдвэрлэлд хамаарах нэмэлт мэдээлэл (асуултад хариулахдаа таны саналтай тохирох дугаарыг тэмдэглэнэ үү)

Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр: \_\_\_\_\_

1. Монголд үйлдвэрлэсэн тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалт (дотоод, гадаадад)-ын жил бүрийн хүлээгдэж байгаа хэмжээ:

- |                          |   |                                   |
|--------------------------|---|-----------------------------------|
| <input type="checkbox"/> | 1 | 1 сая ам.доллар хүртэл            |
| <input type="checkbox"/> | 2 | 1-10 сая ам.доллар хүртэл         |
| <input type="checkbox"/> | 3 | 11-50 сая ам.доллар хүртэл        |
| <input type="checkbox"/> | 4 | 51-100 сая ам.доллар хүртэл       |
| <input type="checkbox"/> | 5 | 100 сая ам.доллар ба түүнээс дээш |

2. Өрсөлдөх чадварын түвшин (хамгийн тохиромжтой гэж үзсэн хоёроос илүүгүй байрлалыг тэмдэглэнэ):

- |                          |   |  |
|--------------------------|---|--|
| <input type="checkbox"/> | 1 | Зөвхөн дотоодын зах зээл дээр өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, үйлчилгээ |
| <input type="checkbox"/> | 2 | Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай                                 |
| <input type="checkbox"/> | 3 | Өрсөлдөөний үлэмж давуу талтай   |
| <input type="checkbox"/> | 4 | Зарчмын цоо шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ                                 |

3. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эхлэх боломжтой хугацаа (шаардлагатайг нь тэмдэглэнэ):

- |                          |   |                   |
|--------------------------|---|-------------------|
| <input type="checkbox"/> | 1 | 1 жилийн дотор    |
| <input type="checkbox"/> | 2 | 1-2 жилийн дараа  |
| <input type="checkbox"/> | 3 | 3-5 жилийн дараа  |
| <input type="checkbox"/> | 4 | 6-10 жилийн дараа |
| <input type="checkbox"/> | 5 | 10 жилээс дээш    |

4. Үйлдвэрлэлийг эхлүүлэхэд зайлшгүй шаардлагатай технологийг эзэмшсэн монголын 1-2 байгууллагыг нэрлэнэ үү (боломжтой бол):

---

5. Шаардлагатай үйлдвэрлэлийн бааз байгаа эсэх:

1. Их хэмжээний хөрөнгө оруулалтгүйгээр үйлдвэрлэлийг зохион байгуулж болох үйлдвэрийн газар бий
2. Нэмэлт хөрөнгө оруулалттайгаар үйлдвэрлэлийг зохион байгуулж болох үйлдвэрийн газар бий
3. Үлэмж хэмжээний хөрөнгө оруулалт хийж, шинэ үйлдвэр байгуулах замаар бүтээгдэхүүн гаргах

6. Бусад мэдээлэл: /саад бэрхшээл, үйлдвэрлэл эхлүүлэх нэмэлт арга хэмжээ, боловсон хүчний ноёд/

---



---



---



---



Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох, тодотгол хийх журмын 3 дугаар хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ЦӨМ ТЕХНОЛОГИЙН КАРТ

Технологийн нэр: \_\_\_\_\_

1. Үндсэн зориулалт: \_\_\_\_\_

2. Бүтэц \_\_\_\_\_

3. Хэрэглэх хүрээ: \_\_\_\_\_

4. Инновацийн чадавхи: \_\_\_\_\_

5. Цөм технологийн жагсаалтад оруулах үндэслэл: \_\_\_\_\_

6. Тухайн салбарт онолын хамгийн их зэхэц бүхий эрдэм шинжилгээний байгууллага: \_\_\_\_\_

7. Зах зээлийн жил бүрийн боломжит хэрэгцээний үнэлгээ: \_\_\_\_\_

8. Тухайн чиглэлийг хамгийн өгөөжтэй хөгжүүлэхэд шаардагдах тусгай арга хэмжээ: \_\_\_\_\_

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

### Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Энхболдод даалгаж, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг холбогдох сайд, аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

1. Засаг захиргааны анхан шатны нэгж "Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах хөрөнгийг тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улс, орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Энхболд, аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийн хүрээнд 2008-2010 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хүрэх үр дүн болон шаардагдах зардлын төсвийн төслийг холбогдох яам, аймгуудад хүргүүлэхийг Монгол

4. Багт ажиллах хүний эмч, түүний унаа, эмнэлгийн багаж хэрэгслийн норматив, багийн сургуулийн өмнөх насны хүүхдийн сургалтын болон сургууль завсардсан хүүхдэд бичиг үсгийн боловсрол олгох журам, багт байгаль орчныг хамгаалах үйлчилгээ, байгаль хамгаалагч ажиллуулах нормативыг орон нутгийн онцлогт тохируулан баталж мөрдүүлэхийг Эрүүл мэндийн сайд Б.Батсэрээдэнэ, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаа, Байгаль орчны сайд Г.Шийлэгдамба нарт даалгасугай.

5. Багийн бүтэц, зохион байгуулалт, ажлын албыг хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, орон

нутгийн онцлогтой нь уялдуулан ялгавартай тогтоох зарчмыг баримтлан холбогдох санал боловсруулж, 2008 оны 1 улиралд багтаан Засгийн газарт оруулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Энхболдод даалгасугай.

6. "Багийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр"-ийг орон нутгийнхаа онцлогт тохируулан боловсруулж, хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга нарт, орон нутгийнхаа нөхцөлд тохирсон жишиг

багийг сум болгонд 2008 онд багтаан бий болгож, багаа ээлж дараатай тохижуулах арга хэмжээ авахыг аймаг, сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** **Н.ЭНХБОЛД**

Засгийн газрын 2008 оны 07 дугаар  
тогтоолын хавсралт

## ЗАСАГ ЗАХИРГААНЫ АНХАН ШАТНЫ НЭГЖ "БАГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР"

### Нийтлэг үндэслэл

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Монгол Улсад нийт 1539 баг, үүний дотор хөдөөгийн 1066 баг үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөдөөгийн нэг багт дунджаар 250 орчим өрх айл, хөдөлмөрийн насны 489 хүн, сургуулийн насны 274 хүүхэд, сургуулийн өмнөх насны 143 хүүхэд ажиллаж, амьдарч байна.

Хөдөөгийн багийн 80.0 орчим хувь нь эрчим хүчний ямар нэгэн эх үүсвэргүй, 66.6 хувь нь холбоотой боловч дийлэнх хэсэг нь тогтмол ажиллахгүй болсон, багийн Засаг дарга нарын 41.3 хувь нь ажиллах байргүй, 32.6 хувь нь иргэддээ хүрч үйлчлэх унаагүй байна.

Багийн Засаг дарга нарын 19.1 хувь нь дээд боловсролтой, 30.5 хувь нь тусгай дунд, 30.9 хувь нь бүрэн дунд, 19.5 хувь нь бага боловсролтой байна.

Ихэнх баг нь Засаг дарга, эмчийн цалингаас өөр төсөвгүй тул бие даан үйл ажиллагаа явуулах боломж хязгаарлагдмал байна.

Баг өөрийн хэмжээнд төрийн үйлчилгээ явуулах байргүй, албан хаагчдын ажиллах нөхцөл муу зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан засаг захиргааны анхан шатны нэгжийн ажлын үр дүн өнөөгийн шаардлагад хүрэхгүй байна.

Хөдөөгөөс суурин газарт чиглэсэн шилжилт хөдөлгөөн нэмэгдэж, хотжих үйл явц эрчимтэй явагдаж байгаа нь багийн бүтэц зохион байгуулалтыг хянан үзэх шаардлагатай байгааг харуулж байна.

### Хөтөлбөрийн зорилго

Засаг захиргааны анхан шатны нэгж багийн хөгжлийг дэмжих замаар төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг шуурхай, чанартай болгох, багийн чадавхийг бэхжүүлэх, баг, иргэд хоорондын харилцааг идэвхжүүлэн тэдгээрийн эрэлт хүсэлтийг шуурхай шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

### Багийн хөгжлийг дэмжих үндсэн зорилтууд

"Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр"-ийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараахь гол зорилтуудыг дэвшүүлж байна.

1. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.
2. Багийн үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх.
3. Багийн удирдлага, иргэд хоорондын харилцааг идэвхжүүлж тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, эрэлт хүсэлтийг шуурхай шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх.

### Багийн хөгжлийг дэмжих үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээ

1.1. Багийн эмчийг үйл ажиллагаа явуулах байртай болгох, эмнэлгийн анхан шатны тусламжийг чанартай хүргэх, эм, эмнэлгийн хэрэгсэл, эмчилгээ-оношилгооны багаж, тоноглолын хангамжийг сайжруулах.

1.2. Хөдөөгийн багийн Засаг дарга, хүний эмч багийн төвд байршин ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

1.3. Багт улирлын сургалт зохион байгуулах, явуулын багш ажиллуулах замаар багийн хүүхэд, залуучуудын бичиг үсгийн боловсролыг

дээшлүүлэх, сургуулийн насны хүүхдийг сургууль завсардуулахгүй байх, малчдыг эрүүл мэндийн болон нийгмийн даатгал, малын даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах, татварын орлого бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэх;

1.4. Багийн хүн амын тоог харгалзан улирлын чанартай гэр-цэцэрлэг ажиллуулах зэргээр сургуулийн өмнөх насны хүүхдийн сургуульд орох бэлтгэлийг хангах арга хэмжээ авах;

1.5. Сум, багаас багийн иргэдэд соёл, урлагийн үйлчилгээ явуулах нөхцөл боломжийг бүрдүүлж, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг тэдний эрэлт хэрэгцээнд тулгуурлан явуулах.

2.1. Багийн Засаг дарга нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Удирдлагын академийн зайны сургалтын төвийг түшиглэн 3-5 жил тутам тэдгээрийн мэргэшлийг дээшлүүлж давтан сургалтад хамруулах арга хэмжээ авах;

2.2. Багт зайлшгүй шаардагдах хөрөнгийг сумын жил бүрийн төсөвт тусган батлуулж, багийн Засаг даргын хяналт, оролцоотойгоор зарцуулах;

2.3. Багийг соёл, хүмүүжил, мэдээлэл сурталчилгааны ажил зохион байгуулахад шаардагдах байр, техник хэрэгсэл болон хуулийн эмхтгэл, гарын авлагаар хангах;

2.4. Тухайн орон нутгийн онцлогт тохируулан багийн Засаг дарга иргэдэд хүрч ажлаа явуулахад шаарлагатай унаа (морь, мотоцикл)-тай болгох;

2.5. Багийн Засаг даргын үйл ажиллагаанд шаардагдах шатахууныг нутаг дэвсгэрийн хэмжээ, ажлын ачааллыг харгалзан олгож байх;

2.6. Боломжтой эх үүсвэрүүдийг ашиглан багийн төвийг эрчим хүчээр хангах арга хэмжээ авах;

2.7. Багийг холбоожуулах, ашиглалтгүй байгаа холбооны хэрэгслийг засч сэлбэн ажилд оруулах.

3.1. Багийн иргэдийн мэргэжлийн болон ерөнхий боловсрол, хууль эрхийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллага, хүмүүсийн дэмжлэг туслалцаа авч зохион байгуулах;

3.2. Багийн иргэдэд төр, засгийн бодлого, нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан шийдвэр, бусад мэдээллийг хүргэх зорилгоор ухууллаг ажиллуулах, "аялах хайрцаг" явуулах зэрэг хэлбэрийг ашиглах, багт шуудан хүргэх ажлыг тогтмол болгох;

3.3. Малтай өрхийн малчидтай хөдөлмөрөө хорших гэрээ, түрээсийн хэлбэрийг нэвтрүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зэрэг замаар малгүй буюу цөөн малтай багийн өрхийг орлогын эх үүсвэртэй болгож, ядуурлыг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

3.4. Багт нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг томилон ажиллуулах зэргээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

3.5. Багийн хэмжээнд малчдын бүлэг, хэсэг байгуулж ажиллуулах замаар байгаль орчныг хамгаалах, малын хулгайгаас сэрэмжлэх арга хэмжээ авах.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт, санхүүжилт, хугацаа:

## Удирдлага, зохион байгуулалт

"Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр"-ийг удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, орон нутгийн түвшинд аймаг, сумын Засаг даргын Тамгын газар хамтран хариуцаж, үр дүнг Засгийн газарт тайлагнана.

Сумын Засаг дарга, багийн Засаг дарга хөтөлбөрт тусгасан арга хэмжээг хамтран хэрэгжүүлнэ.

Нийт аймгийн Засаг даргын Тамгын газар орон нутгийнхаа нөхцөлд тохирсон жишиг багийг 2008 онд сум болгонд бий болгож, багаа ээлж дараатай тохижуулах арга хэмжээг авна.

Багийг эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, холбооны техник хэрэгслийг зайгаар хангаж, засварлан ашиглалтад оруулах ажлыг 2008 онд багтаан хийж гүйцэтгэнэ.

## Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улс болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг "Тогтвортой амьжиргаа" төсөлтэй нягт уялдуулан зохион байгуулж гадаадын зээл, тусламжийн хөрөнгө, иргэд, төрийн бус байгууллагын хандив оролцоо, хувийн хэвшлийн идэвх санаачилгад тулгуурлан хамтран ажиллана.

Хамтын ажиллагааны үр дүнг аймаг, нийслэлийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Иргэдийн Нийтийн Хуралд тус тус тайлагнаж ажиллана.

## Хөтөлбөрийн хугацаа

Засаг захиргааны анхан шатны нэгж "Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр"-ийг 2008-2015 онд хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн үр дүн, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр багийн хөгжилд ахиц гарч, дараахь үр дүнд хүрсэн байна:  
-Багийн Засаг дарга нарын мэдлэг боловсрол дээшилж, үр чадвар ахна.

-Багийн Засаг дарга ажлаа явуулах байр, техник хэрэгсэл, ажиллах нөхцөлөөр хангагдаж, төрийн үйлчилгээ иргэдэд ойртож, түүний нээлттэй, хүртээмжтэй, шуурхай байдал дээшилнэ.

-Хөдөөгийн баг бүр төвтэй болж, засаг захиргааны анхан шатны нэгж болох багийн нэр хүнд дээшилж, багийн ажилд оролцох иргэдийн үйл ажиллагаа сайжирч, иргэний үүргээ биелүүлэн багийг хөгжүүлэхэд тэдгээрийн оролцоо нэмэгдэж, иргэд төрсөн нутагтаа ая тухтай амьдарч, хууль тогтоомж, Засгийн газрын бодлого, шийдвэрийн талаархи мэдээллийг шуурхай хүлээн авах боломжоор хангагдана.

-Хөдөөгийн хүүхэд, залуучуудын сурч, мэдэх нөхцөл сайжирч, хүүхдийн сургууль завсардалт багасна.

-Багийн эмчийн үйл ажиллагаа сайжирч, багийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн анхны тусламж ойртож, тэдгээрийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулна.

-Багийн иргэд хөдөлмөрөө хоршиж орлогын эх үүсвэртэй болж, ажлын байр нэмэгдэн малчдын амьжиргааны түвшин дээшилнэ.

Хөтөлбөрийн үр дүн нь үйл ажиллагааны үндсэн зорилтуудыг хэрэгжүүлсэн дараахь үзүүлэлтээр хэмжигдэнэ:

№	Үндсэн зорилтууд	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар		
		2008-2010	2011-2013	2014-2015
1	Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	38.0	80.0	100.0
2	Багийн үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх	35.0	70.0	95.0-100.0
3	Багийн удирдлага, иргэдийн хоорондын харилцааг идэвхжүүлж, тэдний эрх ашгийг хамгаалах, эрэлт хүсэлтийг шуурхай шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх	38.0	80.0	100.0

**Хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт-шинжилгээ**

Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн

газрын Хэрэг эрхлэх газраас аймгийн Засаг даргын Тамгын газарт хоёр жил тутамд хийж, дүнг Засгийн газарт танилцуулна.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2008 оны 02 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8.1.4, 8.1.5 дахь заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг шийдвэрлэсэн тухай**

*Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 12 цаг 30 минут*

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүдэд Н.Жанцан, П.Очирбат, Д.Наранчимэг /илтгэгч/, Ц.Сарантуяа нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өргөдөл гаргалч Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 3 хорооны оршин суугч, иргэн Б.Лхагважав, мөн хорооны оршин суугч, иргэн Б.Баярсайхан нар хүрэлцэн ирсэн ба Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Үүл, Д.Дондоо нар цэцийн хуралдаанд оролцоогүй болно.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы

хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5 дахь заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

**Нэг. Иргэн Б.Лхагважав, Б.Баярсайхан нар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн өргөдөлдөө:**

"Монгол Улсын Их Хурлаас 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдөр баталсан "Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 8.1.4-т "Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх, огцруулах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв зэрэг асуудлыг хэлэлцэхэд гишүүн нам, эсэргэцлийн бүлэг дээр тогтсон бодлого, зарчмыг удирдлага болгох" мөн 8.1.5-т "энэ хуулийн 8.1.4-т зааснаас бусад хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл,

тодорхой асуудал хэлэлцэхэд гишүүн өөрийн байр сууринаас хандаж үг хэлэх, санал хураалтанд оролцох" гэсэн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн дараахь зүйлийг зөрчсөн байна. Үүнд:

1. Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн"

2. Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг "Монгол Улсад Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ"

3. Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг "Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхолыг эрхэмлэн баримтлана"

4. Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт "төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах" гэсэн хэм хэмжээг тус тус зөрчсөн байна.

Иймд Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн "Монгол Улсын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5 дахь заалтуудыг хүчингүй болгож өгнө үү" гэжээ.

**Хоёр. Монгол Улсын Их хурлын даргын 2008 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 27 тоот захиралжаар томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Э. Бат-Уул, Д. Дондог нар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:**

"... Улсын Их Хурлаас 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдөр баталсан Монгол Улсын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтыг зөрчсөн тухай Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 3 дугаар хорооны иргэн Б.Лхагважав, Б.Баярсайхан нарын Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлтэй танилцаад дараахь тайлбарыг гаргаж байна.

Аливаа улс оронд "нийгмийн ашиг сонирхол болон өөрсдийн /хувийн/ үзэл бодлын үүднээс сайн дураараа эвлэлдэн нэгдэж" нам байгуулах үйл ажиллагаа нь тухайн нийгмийн улс төрийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр байдаг. Тийм ч учраас

2005 онд батлагдсан Улс төрийн намын тухай Монгол Улсын хуулийн 4.1-д "Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн" гэж тодорхойлсон. Энэ нь аливаа намын гол зорилго нь засгийн эрхийг барихын төлөө үйл ажиллагаа байдаг.

Ялангуяа улс төрийн намын сонгуулийн мөрийн хөтөлбөр нь нийт иргэн, улсын ашиг сонирхлыг хамгаалсан, нийгмийн амьдралын төлөө юу хийж чадах тэр бүхнийгээ төлөвлөн дэвшүүлэн тавьдаг. Тухайн намын энэхүү мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн төлөө ард түмнийгээ төлөөлөн парламентын гишүүн ажиллах шаардлагатай болдог. Энэ агуулгаар аваад үзэхэд сонгогч нэр дэвшигчийг дэмжиж санал өгч байгаа ч тэр нэр дэвшигчийн харьяалах намын мөрийн хөтөлбөрийг дэмжиж байгаа хэрэг гэж үздэг.

Тухайн нам нь Монгол Улсын хууль тогтоомж, үндэсний эрх ашигт нийцсэн өөрийн үзэл баримтлал, үйл ажиллагааны зарчим, эрхэм зорилго, тэдгээрийг хэрэгжүүлэх үндсэн арга замыг тодорхойлсон мөрийн хөтөлбөртэй байдаг бөгөөд хувь хүн хувийн үзэл бодол, санаагаараа тэдгээрийг дэмжиж, түүнтэй санал нэгдсэний үндсэн дээр гишүүн нь болж үйл ажиллагаанд нь оролцдог. Энэ байдал ч парламентад суудалтай намуудын үйл ажиллагаанд илэрхийлэгдэж байдаг.

УИХ дахь намын бүлэг бүрээр хэлэлцэж байгаа асуудал нь сайн шүүгдэж, нэгдмэл санаанд хүрсэн бол чуулганы хуралдаан дээр үр ашиггүй маргаан, санал зөрөлдөх явдал бага гарна гэж үздэг. Энэ жишиг парламентат улс орнуудад нийтлэгээр дагаж мөрдөгдөж байна. Улс төрийн намын бүлэг нь парламентын ганц гишүүнээс илүүгээр Засгийн газар, нийгэм хоёрыг холбох гол үүргээ гүйцэтгэж чаддаг болох нь амьдралаар нотлогдсон гэж үздэг. Нөгөө талаар намын сахилга бат бол парламент дахь улс төрийн намын бүлгийн чадвар, түүний гишүүдийнх нь удирдлагынхаа бодлогыг хэр дэмжиж байгааг оршдог.

Олон улсын практикаас харахад ардчилсан либерал үзэл ихэвчлэн намын лидерүүд парламентын гишүүн болж байдаг буюу "удирдлагыг дамжуулдаг" тогтолцоо байдаг. Намын сахилга бат нь Вестминстер тогтолцооны шиг болон Англи, Канад, Австрали, Энэтхэг шиг их хатуу байх хандлагатай байдаг. Энэ нь Засгийн газрын эсрэг парламентад санал хураалгагдаггүй байдал нь Засгийн газрын бодлогыг "унагах, сүйрэлд" оруулахгүй байхаар тохиролцохоос гадна намын байр суурийг гишүүд дэмжиж ажилладагтай холбоотой юм. Энэ нөхцөл байдалд өөрийн намын хүсэл, бодлогын эсрэг ажиллах гишүүд ховор

байдаг. Тийм учраас намын байр суурийг харгалзан парламентын санал хураалтад оролцдог байна.

Онолын хувьд парламентын гишүүн бол ард түмний элч, тэднийг төлөөлж байдаг. Гэхдээ практикт парламентын гишүүн нь намаас нэр нь дэвшигдэж, ард түмэн түүнийг сонгох, эс сонгохоо шийддэг. Тухайн нэр дэвшигч ард түмнээс сонгогдож гарч ирдэг боловч өөрийн харьяалах намтайгаа гэрээ байгуулж нэг талаас улс төрийн бодлогыг тодорхойлоход намын байр суурийг, нөгөө талаас ард түмний нийтлэг эрх ашгийг тус тус илэрхийлж оролцох шаардлагатай болдог. Энэ агуулгаар авч үзвэл ямарч нөхцөлд парламентын гишүүн хоёрдмол байр сууринд ирдэг. Иймээс ихэнх улс оронд парламентын гишүүний энэхүү хоёрдмол байр суурийг зохицуулах үүднээс тодорхой асуудлуудыг ялангуяа улс төрийн бодлогын үүднээс хандаж асуудалд парламент дахь намын бүлгийн баримталж байгаа зарчим, бодлогыг дагаж мөрдөхөөр зохицуулдаг нь үүнтэй холбоотой юм.

Гэхдээ зөвхөн улс төрийн шалтгаанаар ийнхүү нэгдэж ажилладаг бөгөөд ийм ч учраас бүх асуудлаар бус зөвхөн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх, огцруулах, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, улсын төсвийн хэлэлцэхэд л УИХ дахь нам, эвслийн бүлэг дээр тогтсон бодлого, зарчмыг удирдлага болгож гишүүн байр сууриа илэрхийлж байхаар тусгасан юм. Ялангуяа парламентад олонхи суудал авсан улс төрийн намын үйл ажиллагааны болон сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болдог бөгөөд түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө үйл ажиллагаагаа явуулахыг эрмэлздэг тул намын сахилга батыг илүү харгалзах шаардлага гарч байдаг. /парламентад суудалтай бусад намд ч энэ байдал хамаарч байдаг/

Энэ бүхнээс үзэхэд дээрх заалт нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй болно.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5-д дээрх тусгайлан заасан асуудлаас бусад асуудлыг хэлэлцэхэд УИХ-ын гишүүн өөрийн үзэл бодол, байр сууринаас хандаж үг хэлэх, санал хураалтад оролцохоор заасан бөгөөд энэ заалтыг мөн адил Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн тухай өргөдөл гаргагчид үзсэн байна. Хуулийн 8.1.4-т тусгайлан заасныг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзсэн атлаа өөрийн үзэл бодлоор хандах энэ заалтыг Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэж үзэж байгаа нь хоорондоо зөрчилдөж байна. УИХ-ын гишүүний нам, эвслийн бүлэг дээр тогтсон бодлого, зарчмаар, эсхүл өөрийн үзэл бодлоор хандахын аль алиныг

нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэж үзэж байгаа нь ойлгомжгүй байна.

Тэгвэл гишүүн асуудалд хэрхэн хандах ёстой вэ, өөр гуравдахь хандлагаар хандах хэрэг гарч байгаа биш үү. Тэгээд ч өргөдөл гаргагчид Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох заалтууд нь ямар үндэслэлээр Үндсэн хуулийн тухайн заалтуудтай зөрчилдөж байгаа талаар огт дурьдаагүй байна.

Өөрөөр хэлбэл, иргэн Б.Лхагважав, Б.Баярсайхан нар Цэцэд өргөдөл гаргахдаа түүнд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4-т заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох заалтууд Үндсэн хуулийн тухайн заалтуудтай зөрчилдөж байгаа үндэслэл, бусад нөхцөл байдал, тэдгээрийн нотолгоог тусгааргүй байна.

Мөн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу иргэнээс гаргасан өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгаж өргөдөл, мэдээлэл нь энэ хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзаж тогтоол гаргахаар заасан.

Дээр дурьдсан үндэслэлээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5 дахь заалтууд нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэх үндэслэлгүй гэж үзэж байна” гэжээ.

Өргөдөл гаргагч нар УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “...хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл, тодорхой асуудал хэлэлцэхэд гишүүн өөрийн байр сууринаас хандаж үг хэлэх, санал хураалтад оролцох” гэсэн хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалт зөрчсөн гэсэн шаардлагаасаа Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад татгалзсан болно.

## ҮНДЭСЛЭЛ:

Улсын Их Хурлын гишүүн ард түмний элч, нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлах Үндсэн хуулийн үүрэгтэй атал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4-д заасан асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэхэд “гишүүн нам, эвслийн бүлэг дээр тогтсон бодлого, зарчмыг удирдлага болгож байхаар” хуульчилсан нь Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хязгаарласан гэх үндэслэлтэй байна.

Харин дээрх заалтаар Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7/-д заасан Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх хөндөгдсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтуудыг удирдлага болгон

### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ НЬ:

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын "Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх, огцруулах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв зэрэг асуудлыг хэлэлцэхэд гишүүн нам, эвслийн бүлэг дээр тогтсон бодлого, зарчмыг удирдлага болгох" мөн 8.1.5 дахь заалтын "энэ хуулийн 8.1.4-т зааснаас бусад..." гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ", Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний эгч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална" гэснийг тус тус зөрсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын "Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх, огцруулах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв зэрэг асуудлыг хэлэлцэхэд гишүүн нам, эвслийн бүлэг дээр тогтсон бодлого, зарчмыг удирдлага болгох" мөн 8.1.5 дахь заалтын "энэ хуулийн 8.1.4-т зааснаас бусад..." гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7/-д заасан "төрийн санхүү, эзэл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний үйлцэтгэлийн тайланг батлах," гэснийг зөрчөөгүй байна.

3. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 8.1.5 дахь заалтын "энэ хуулийн 8.1.4-т зааснаас бусад..." гэсэн хэсгийн үйлчлэлийг 2008 оны 2 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт нь Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлснээс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Ж.БЯМБАДОРЖ

ГИШҮҮН

П.ОЧИРБАТ  
Н.ЖАНЦАН  
Д.НАРАНЧИМЭГ  
Ц.САРАНТУЯА

### МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 07-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

#### ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ООРЧЛОЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ШҮҮХИЙН ПРАКТИКТ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ

2008 оны 2 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хурлаар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг /цаашид Эрүүгийн хууль гэнэ/ баталсныг 2008 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн даган мөрдөж байгаа билээ.

Энэхүү хуулиар урьд нь гэмт хэргэг тооцож байсан зарим хэргийг гэмт хэргэг тооцохгүй байх, зарим үйлдлийг шинээр гэмт хэргэг тооцох болон зарим төрлийн ялын хугацаа, хэмжээг нь өөрчилснөөс гадна зарим зүйлд заасан хорих ялын доод, дээд хэмжээг багасгах буюу өсгөх зэрэг үндсэн өөрчлөлтүүдийг оруулжээ.

Иймд энэ хуулийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаанд нэг мөрийгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.3, 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. 2002 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдгийн хуулиар Эрүүгийн хуулийн 163 дугаар зүйл /Хууль бусаар олж авсан эд хөрөнгө, мөнгөийг ашиглах/, 167 дугаар зүйл /Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль



тогтоомж зөрчих/. 239 дүгээр зүйл /Төрийн дайчилгаанаас зайлсхийх/. 267 дугаар зүйл /Албан тушаалтны нэр барих/. 272 дугаар зүйл /Албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах/. 103 дугаар зүйл /Бэлгийн замын халдварт өвчин халдаах/-ийн 1 дэх хэсэг, 155 дугаар зүйл /Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах/-ийн 2 дахь хэсэг, 230 дугаар зүйл /Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх/-ийн 1 дэх хэсгийг тус тус гэмт хэрэгт тооцохгүй болсон тул эдгээр зүйлд заасан гэмт хэрэг үйлдэн шүүхээр ял шийтгүүлж, ял эдэлж байгаа хүмүүсийг эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялаас чөлөөлнө.

Хэрэв хэргийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага шалгаж байгаа бол прокурорын тогтоолоор, яллагдагчийг шүүхэд шилжүүлээгүй тохиолдолд шүүгчийн захирамжаар, яллагдагчийг шүүхэд шилжүүлсэн бол шүүх хуралдаанаас тус тус хэрэгсэхгүй болгоно.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт ял шийтгүүлж, ял эдэлсэн буюу уг тогтоолын дагуу ялаас чөлөөлөгдсөн хүмүүсийг ялгүйд тооцно.

3. Уг тогтоолын 1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт урьд ял шийтгүүлж, тухайн зүйл, хэсгээр оногдуулсан ял нь **Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцогдох зүйл, хэсгээр оногдуулсан ялд багтсан** бол эдэлсэн ялыг хувь тэнцүүлэн тооцож, гэмт хэрэгт тооцогдохгүй болсон зүйл, хэсгээр оногдуулсан ялаас чөлөөлж, гэмт хэрэгт тооцсон нь хэвээр байгаа зүйл, хэсгээр оногдуулсан ялын эдлээгүй үлдсэн хэсгийг эдлүүлнэ.

Харин **Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцогдохгүй болсон зүйл, хэсгээр оногдуулсан ялд** Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцсон хэвээр байгаа зүйл, хэсгээр оногдуулсан ялыг багтаасан байвал эдэлсэн ялыг хувь тэнцүүлэн тооцож, багтаасан хүнд ялаас хугацааг харгалзахгүй чөлөөлж, уг багтсан ялаас эдлээгүй үлдсэн хэсгийг эдлүүлнэ. Хэрэв уг багтсан ялыг эдэлсэн байвал ялаас бүрэн чөлөөлнө.

Түүнчлэн Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцогдохгүй болсон зүйл, хэсгээр оногдуулсан ялыг өөр зүйл, хэсгээр оногдуулсан ялтай нэмж нэгтгэсэн байвал гэмт хэрэгт тооцогдохгүй болсон зүйл хэсгээр оногдуулсан ялыг шууд хасч тооцно.

4. 2008 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө ял шийтгүүлсэн этгээдэд шүүхээс оногдуулсан ял нь 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн нэмэлт, өөрчлөлт оруулсан Эрүүгийн хуулийн зохих зүйл, хэсэгт зааснаар оногдуулж болох тухайн төрлийн ялын дээд хэмжээнээс дээгүүр байвал уг ялыг нэмэлт, өөрчлөлт оруулсан Эрүүгийн хуульд заасан ялын дээд хэмжээнд нийцүүлж хасна.

5. 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан Эрүүгийн хуулиар гэмт

хэрэгт шинээр тооцохоор заасан зүйл, хэсгүүдийг 2008 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 00 цагаас хойш үйлдэгдсэн гэмт хэрэгт хэрэглэнэ.

Мөн хуулиар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.1, 146 дугаар зүйлийн 146.1, 148 дугаар зүйлийн 148.1, 150 дугаар зүйлийн 150.1 дэх хэсгүүдэд "бага бус хэмжээний хохирол учирсан" гэсэн бүрэлдэхүүнийг шинээр нэмсэн тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг үндэслэн 2008 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 00 цагаас өмнө бусдын эд хөрөнгийг хулгайлах /Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйл/, булаах /Эрүүгийн хуулийн 146 дугаар зүйл/, залилан мэхлэж авах /Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйл/, завших, үрэгдүүлэх /Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйл/ гэмт хэрэг үйлдэн шүүхээр ял шийтгүүлж, ял эдэлж байгаа хүмүүсийн бусдад учруулсан хохирлын нийт хэмжээ нь Засгийн газрын 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох" тухай 350 дугаар тогтоолд заасан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 108.000 /нэг зуун найман мянган/ төгрөгт хүрэхгүй байвал тэдгээрийг эдлээгүй үлдсэн болон нэмэгдэл ялаас чөлөөлнө.

Харин дээр дурдсан гэмт хэргийг үйлдсэн этгээдийн бусдад учруулсан хохирлын нийт хэмжээ нь 108.000 /нэг зуун найман мянган/ төгрөг ба түүнээс дээш байгаа тохиолдолд Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхгүй.

Хэрэв хэргийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага шалгаж байгаа бол прокурорын тогтоолоор, яллагдагчийг шүүхэд шилжүүлээгүй тохиолдолд шүүгчийн захирамжаар, яллагдагчийг шүүхэд шилжүүлсэн бол шүүх хуралдаанаас тус тус хэрэгсэхгүй болгоно.

6. 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан Эрүүгийн хуулийн зүйл, хэсгийн заалтаас өмнө хуулийн тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн **бүрэлдэхүүн** нь хасагдсан байвал чухамхүү тэр бүрэлдэхүүнээр шийтгүүлсэн хүмүүсийг эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялаас чөлөөлж, ялгүйд тооцно. Гэмт хэргийн бүрэлдэхүүн нь хасагдсан боловч өөр төрлийн гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнээр зүйлчлэгдэх болсон тохиолдолд ялаас чөлөөлөхгүй бөгөөд ялгүйд тооцохгүй.

7. Тодорхой гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнээр шийтгүүлж, одоо ял эдэлж байгаа этгээдийн үйлдэл нь нэмэлт, өөрчлөлт оруулсан Эрүүгийн хуулиар тухайн гэмт хэргийн энгийн бүрэлдэхүүнээр эсхүл хорихоос өөр төрлийн хөнгөн ял оногдуулж болох зүйл, хэсгээр зүйлчлэгдэх болсон бол уг хэргийг хянаж байгаа шүүх буюу уг ялыг эдлүүлж байгаа газрын харьяалах шүүх болон харьяалал тогтоосон шүүхийн шүүгч захирамж, шүүх тогтоол гарган хуульд нийцүүлж шийдвэрлэнэ.

Жишээ нь: 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.4 дэх хэсгээс "...энэ хэрэгт хоёр буюу түүнээс дээш удаа шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол..." гэсэн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг хассан тул урьд нь энэ хүндрүүлэх бүрэлдэхүүнээр хэргийг зүйлчилж, 10-аас дээш жил хорих ялаар шийтгүүлэн, ял эдэлж байгаа этгээдийн хэргийг одоо даган мөрдөж буй Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн аль тохирох хэсгээр зүйлчилж, ялыг хуульд нийцүүлэн хасна. Ийнхүү хасахдаа хорих ял эдлэх дэглэмийн асуудлыг хамтад нь шийдвэрлэнэ.

8. 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан Эрүүгийн хуулиар тодорхой төрлийн гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээ өмнөх хуульд зааснаас хүндэрч тогтоогдсон бол гэмт этгээдэд оногдуулсан буюу оногдуулах ялыг хүндрүүлэхгүй бөгөөд энэ нь 2008 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө үйлдэгдсэн гэмт хэрэгт хамаарна.

Харин одоо даган мөрдөж байгаа Эрүүгийн хуулийн тодорхой зүйл, хэсэгт заасан гэмт хэрэгт ял эдэлж буй болон шийтгүүлж байгаа этгээдийн хорих ялын доод хэмжээ багассан тохиолдолд 2002 оны Эрүүгийн хуулийн тухайн зүйл, хэсгийн доод хэмжээгээр оногдуулсан ялыг нэмэлт, өөрчлөлт оруулсан Эрүүгийн хуулийн тухайн зүйл, хэсэгт заасан доод хэмжээнд нийцүүлэн хасч тогтооно.

9. Нэг төрлийн гэмт хэргийг давтан болон үргэлжилсэн үйлдлээр хийсний сүүлчийн үйлдэл нь 2008 оны 2 дугаар сарын 25-наас хойш гарсан байвал нэмэлт, өөрчлөлт оруулсан Эрүүгийн хуулиар зүйлчилж шийдвэрлэнэ.

10. 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 55<sup>1</sup> дугаар зүйлийн 55<sup>1</sup>.1-д заасан "...хорих ялын доод хэмжээний гуравны хоёроос хэтрэхгүй байна", 62<sup>1</sup> дугаар зүйлийн 62<sup>1</sup>.1-д

заасан "...хорих ялын доод хэмжээний хоёрны нэгээс хэтрэхгүй байна" гэснийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн тухайн зүйл, хэсэгт хорих ялын доод хэмжээг заасан тохиолдолд л хэрэглэнэ.

Дээрх зүйл, хэсгүүдэд заасан "**Хэтрэхгүй байна**" гэдэгт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 55<sup>1</sup> дугаар зүйлийн 55<sup>1</sup>.1-д "...хорих ялын доод хэмжээний **гуравны хоёроос**...", 60 дугаар зүйлийн 60.2-т "...аль хүнд төрлийн ялын доод хэмжээний **хоёрны нэгээс**...", 60.3-т "...аль хүнд төрлийн ялын доод хэмжээний **гуравны хоёроос**...", 62<sup>1</sup> дугаар зүйлийн 62<sup>1</sup>.1-д "...хорих ялын доод хэмжээний **хоёрны нэгээс**..." гэж тус тус заасан хэмжээнээс доогуур хорих ял оногдуулахгүй байхыг ойлгоно.

11. Хэрэв Эрүүгийн хуулийн тусгай ангийн тухайн зүйл, хэсэгт хорих ялын доод хэмжээг заагаагүй бол мөн хуулийн 55<sup>1</sup>, 62<sup>1</sup> дугаар зүйлүүдийг хэрэглэхгүй.

12. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 12 дугаар зүйлд зааснаар оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн, тухайн хэргийг гэмт хэрэгт тооцохгүй болсон, тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын доод дээд хэмжээг багасгасан тохиолдолд урьд нь үүнээс дээгүүр ял шийтгүүлсэн этгээдийн ялыг доод хэмжээнд нийцүүлэх, хасах, ялаас чөлөөлөх зэрэг ажиллагааг 2008 оны 4 дүгээр сарын 1-ний дотор харьяалах хорих ангитай хамтран хийж гүйцэтгэх, дүнг Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимд мэдээлэхийг аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч нарт үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ С.БАТДЭЛГЭР

ТАНХИМЫН ТЭРГҮҮН Д.БАТСАЙХАН

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 07-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

### ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН 33 ДУГААР ЗҮЙЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль /цаашид хуулийн гэх/-ийн 33 дугаар зүйлийн 33.1-д

заасан "Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагч ..." гэдэгт онцгой байдлын асуудал эрхэлсэн төв, орон нутгийн байгууллагад ажиллаж байгаа төрийн тусгай болон үйлчилгээний нийт албан хаагчид хамаарна.

2. Мөн зүйлийн 33.7-д заасан "Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тусгай албан тушаал эрхэлдэг албан хаагч ..." гэдэгт

хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, 32 дугаар зүйлд заасны дагуу тангараг өргөж, ажил, мэргэжлийн онцлогт тохирсон цол, дүрэмт хувцас хэрэглэдэг, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтныг хамааруулан ойлгоно.

3. Мөн зүйлийн 33.12-т заасан “Аврах ажиллагаанд оролцдог албан хаагч...” гэдгийг онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тусгай албан тушаал эрхэлдэг албан хаагч гэж ойлгох бөгөөд тэдгээрт хуулийн

33 дугаар зүйлийн 33.12.2, 33.12.3, 33.12.4, 33.12.5, 33.12.6-д заасан нэмэлт хөнгөлөлтийг эдлүүлнэ.

Харин тэдгээрээс аврах ажиллагаа явуулсан тохиолдолд хуулийн 33 дугаар зүйлийн 33.12-д заасан урамшууллыг холбогдох байгууллагаас гаргасан журамд зааснаар олгоно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

П.ЦЭЦГЭЭ

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

### ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 113 ДУГААР ЗҮЙЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

**Нэг.** Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг дор дурьдсанаар тайлбарласугай.

1.1. “Хүн худалдаалах” гэдэгт тодорхой төлбөртэйгөөр (мөнгө авах, эд хөрөнгө болон түүнийг өмчлөх эрхээр солилцох г.м) эсхүл ямар нэгэн үүргийн гүйцэтгэлд тооцож (өрөнд өгөх г.м) хүнийг бусад хүмүүсийн мэдэлд бүр мөсөн буюу тодорхой хугацаагаар шилжүүлэхийг ойлгоно.

1.2. “Ашиг олох зорилгоор” гэж хүн худалдаалах замаар өөртөө болон бусад этгээдэд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус ашигтай байдал, орлого бий болгохыг хэлнэ.

1.3. “Хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн” гэдгийг Улсын Дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоолын 1.4-т зааснаар ойлгоно.

1.4. “Хууран мэхэлсэн” гэж үгээр буюу үйлдлээр, бодит байдлыг нуун дарагдуулах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар бусдыг төвөгдүүлэхийг хэлнэ.

Энэ нь гадаад улсад ажиллах, суралцах, аялах, гэрлэхэд зуучлах зэргээр худал амлах хэлбэрээр илэрнэ.

1.5. “Эмзэг байдлыг нь далимдуулсан” гэдэгт хохирогчийн эдийн засаг, эрүүл мэнд болон хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, түүнчлэн амьдрал ахуйн бусад хүнд байдал зэргийг ашигласан байхыг ойлгоно.

1.6. “Элсүүлсэн” гэж хүнийг худалдаалах зорилгоор тухайн болон бусад этгээдийг айлган сүрдүүлэх, тулган шаардах, ялгах замаар гэмт ажиллагааны оролцогч болгох аливаа үйлдлийг

хэлнэ. Хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэхдээ бусдыг татан оролцуулахаас гадна хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй болон эрхшээлдээ байгаа байдал зэргийг далимдуулан зөвшөөрүүлэх явдал нь энэ ойлголтод нэгэн адил хамаарна.

1.7. “Тээвэрлэсэн” гэдэгт хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй хүнийг нэг газраас нөгөөд бүх төрлийн тээврийн хэрэгслээр ил болон далд хэлбэрээр зөөвөрлөхөөс гадна уг ажиллагаанд бүх талын дэмжлэг тусалцаа үзүүлэхийг ойлгоно.

Хүн худалдаалж байгаа этгээд өөрөө тээвэрлэсэн бол энэ нь түүний гэмт үйлдлийн нэг хэсэг болно.

1.8. “Дамжуулсан” гэж хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд хүнийг гуравдагч улсын нутаг дэвсгэрээр дамжуулан хил нэвтрүүлэх, нэг этгээдээс нөгөөд хүнийг шилжүүлэх болон уг ажиллагаанд бүх талын дэмжлэг тусалцаа үзүүлэхийг хэлнэ.

1.9. “Орогнуулсан” гэдэгт хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй хүнийг хүлээн авах этгээдэд шилжих хүртэл түр хугацаагаар өөрийн, эсхүл бусдын орон байранд хяналттай болон хяналтгүйгээр нуугдуулан байрлуулахыг ойлгоно.

1.10. “Хүлээн авсан” гэж худалдаалагдсан хүнийг өөрийн мэдэлд байлгаж, ашиглахаар шилжүүлэн авахыг ойлгоно.

1.11. “Эрх мэдлээ урвуулан ашиглах” гэдэгт хууль тогтоомж буюу эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийн дагуу өөрт нь олгогдсон албаны болон бусад бүрэн эрхийг санаатайгаар харш ашигласан явдлыг хамааруулж үзнэ.

1.12. “Эрхшээлдээ байгаа” гэдэгт эд хөрөнгийн болон бусад нөхцөл байдлын улмаас тухайн этгээдээс хараат байхыг ойлгоно.

1.13. “Хил давуулан” гэдэгт хүнийг худалдаалахын тулд улсын хилийг нууцаар, эсхүл

хуурамч буюу хууль ёсоор олж авсан баримт бичиг ашиглан илээр нэвтрүүлэхийн аль аль нь хамаарна.

Хүнийг хил давуулан худалдаалахдаа хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлсэн бол Эрүүгийн хуулийн 89 дүгээр зүйлээр давхар зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

1.14. "Хүнд хор уршиг учирсан" гэдэгт хүнийг худалдаалахтай шууд холбоотойгоор амьнас нь хохирсон, амиа хорлоход хүргэсэн, бие махбодид нь хүнд гэмтэл учирсан, сэтгэгийн болон бусад хүнд өвчнөөр өвчилсөн, түүнчлэн эд хөрөнгийн хувьд хохирол учирсан зэрэг үр дагавар бий болсныг ойлгоно.

Хоёр, Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн тайлбарын 1 дэх хэсгийн зарим заалтыг дор дурьдсанаар тайлбарласугай.

2.1. "Биеийг нь үнэлүүлэх" гэж хохирогчийн хүсэл зоригоос гадуур түүнийг бусадтай бэлгийн харьцаанд төлбөртэй оруулахыг хэлнэ.

"Бэлгийн хүчирхийлэлд оруулах" гэдэгт биеийг нь үнэлүүлэхээс гадна тулган шаардах, хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж садар самууныг сурталчлахад татаж оруулсан, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан аливаа үйлдэл хийсэн зэргийг ойлгоно.

Өрийн дарамтад оруулах зэргээр биеийг нь үнэлүүлсэн болон бусад хэлбэрээр бэлгийн хүчирхийлэлд оруулсан бол үүнд нэгэн адил хамаарна.

2.2. "Алдаан хөдөлмөр хийлгэх" гэдэгт хүний хүсэл зоригоос гадуур түүгээр аливаа ажил үйлчилгээг төлбөргүйгээр гүйцэтгүүлэхийг хэлнэ.

2.3. "Боолчлох" гэдэгт эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус өмчлөх эрхэд хамаарах бүх, эсхүл зарим эрхийг хүн дээр хэрэгжүүлж, түүний төрөлхийн болон жам ёсны бүх эрхийг хориглох буюу хязгаарлахыг ойлгоно.

2.4. "Боолчлолтой ижил төстэй нөхцөлд байлгах" гэж хуульд харшилсан зан заншил, уламжлал, шашин шүтлэг зэрэгтэй холбоотойгоор хүний төрөлхийн болон жам ёсны бүх эрхийг хориглох буюу хязгаарлах явдлыг хэлнэ.

2.5. "Эд эрхтнийг нь авч ашиглах" гэдэгт хүний цус, нөхөн уржихуйн эд (өндгөөч, төмсөг, өндгөн эс, сүн, ураг)-ээс бусад эд эрхтнийг ашиг олох зорилгоор, хууль бусаар авсан үйлдлийг хамааруулж үзнэ.

Гурав, Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн 113.2.3-т заасан хүн хулгайлах хэрэг нь хүнийг худалдаалах зорилготой байдгаараа мөн хуулийн 108 дугаар зүйлд заасан гэмт хэргээс ялгагдана.

Хүнийг худалдаалах зорилгоор хулгайлсан нь энэ гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн тул энэ тохиолдолд Эрүүгийн хуулийн 108 дугаар зүйлээр давхар зүйлчлэхгүй.

Дөрөв, Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн тайлбарын 1 дэх хэсгийн "биеийг нь үнэлүүлэх" гэдэг нь мөн хуулийн 124 дүгээр зүйлд заасан "биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах,

биеэ үнэлэхийг зохион байгуулах" гэмт хэргээс дараах шинжээр ялгагдана.

4.1 Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан "биеийг нь үнэлүүлэх" гэдэг нь хохирогчийн хүсэл зоригоос гадуур, тулган шаардаж, хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, түүнийг бэлгийн харьцаанд оруулдаг бол мөн хуулийн 124 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний хувьд энэ нь заавал байх шинж биш болохыг анхаарвал зохино.

4.2 Хүнийг худалдаалах гэмт хэргийн хохирогчийг бусад хүмүүсийн мэдэлд бүрмөсөн буюу тодорхой хугацаагаар, төлбөртэйгээр эсхүл ямар нэгэн үүргийн гүйцэтгэлд тооцож шилжүүлдэг бол биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулсан, зохион байгуулсан, зуучилсан гэмт хэргийн хувьд ийм шинж байдаггүйгээр ялгагдана.

4.3 Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт хохирогчийн биеийг нь үнэлүүлсэн болон бусад хэлбэрээр бэлгийн хүчирхийлэлд оруулсны орлого бүхэлдээ гэмт этгээдийн ашиг болдог бол мөн хуулийн 124 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн хувьд ашиг, орлогын тодорхой хэсэг нь гэмт этгээдийн мэдэлд шилжинэ.

Түүнчлэн биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулсан, зохион байгуулсан, зуучилсан гэмт хэргийн хохирогчид биеэ үнэлсний орлогын зарим хэсэг үлдэж бол Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хувьд ийм шинж байдаггүйгээр ялгагдана.

4.4 Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хувьд хохирогчийн эрх, эрх чөлөө гэмт этгээдээс бүрэн хамааралтай, боолчлогдох шинжтэй бол мөн хуулийн 124 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн тухайд биеэ үнэлж байгаа этгээд нь гэмт этгээдээс ямар нэгэн байдлаар хараат байх боловч эрх, эрх чөлөө нь бүрэн хязгаарлагдсан шинжгүй байна.

4.5 Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хохирогч "биеийг нь үнэлүүлэх" -ийг урьдчилан мэдээгүй байдаг бол мөн хуулийн 124 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн хувьд биеэ үнэлж байгаа этгээд үүнийг урьдчилан мэдсэн байдгаараа ялгагдана.

4.6 Биеийг нь үнэлүүлэх болон бусад хэлбэрээр бэлгийн хүчирхийлэлд оруулсан үйлдлийг Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлээр давхар зүйлчлэхгүй.

Тав, Хүн худалдаалах тухай хэлцэл (амаар болон бичгээр) хийгдсэн болон талууд үүргээ гүйцэтгэсэн эсэхээс үл хамааран хүнийг худалдаалахаар элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, оронуулсан, хүлээн авсан, эсхүл дээрх үйлдлүүдэд бэлтгэсэн, завдсан бол хүн худалдаалах гэмт хэргийг төгс үйлдэгдсэнд тооцно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Д.БАТСАЙХАН

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

### ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 146 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН "БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ БУЛААХ" ГЭМТ ХЭРГИЙГ 147 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН "БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ ДЭЭРЭМДЭХ" ГЭМТ ХЭРГЭЭС ЯЛГАЖ, ЗӨВ ЗҮЙЛЧЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДЛЫН ТАЛААР

Эрүүгийн хуулийн 146, 147 дугаар зүйлийн зарим заалтыг нэг мөр ойлгох, "бусдын эд хөрөнгийг булаах" гэмт хэргийг "дээрэмдэх" гэмт хэргээс ялгаж, зөв зүйлчлэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.3, 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс **ТОГТООХ нь:**

1. Эрүүгийн хуулийн 146 дугаар зүйлд заасан "Бусдын эд хөрөнгийг булаах" /цаашид "булаах" гэнэ/ гэмт хэрэг нь мөн хуулийн 147 дугаар зүйлд заасан "Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх" /цаашид "дээрэмдэх" гэнэ/ гэмт хэрэгтэй бусдын эд хөрөнгийг шунахай сэдэлтээр, ил аргаар, хууль бусаар, үнэ төлбөргүйгээр өөртөө болон бусдын өмчлөлд бүр мөсөн авч, хууль ёсны өмчлөгчид хохирол учруулсан шинжтэй байдгаараа өөр хоорондоо төсөөтэй болохыг анхаарвал зохино.

2. "Булаах" гэдэгт бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр авсан, өөрөөр хэлбэл хохирогчид бие махбодийн болон сэтгэл санааны ямар нэг хүч хэрэглээгүй, хэрэглэхээр заналхийлээгүй, зөвхөн ил аргаар эд хөрөнгийг нь салган авч тэр даруйдаа хохирогчоос зугтан зайлсхийсэн шинжтэй үйлдэл хамаарна.

Тухайлбал, хохирогчийн өмсөж явсан малгайг нь шүүрэх, нийтийн үйлчилгээний газрын пангуу, ширээн дээрээс эд зүйлийг авч зугтах гэх мэт.

3. "Дээрэмдэх" гэдэгт бусдын эд хөрөнгийг хууль бусаар авахад саад болж байгаа аливаа этгээд (өмчлөгч буюу эзэмшигч, итгэмжлэгдэн хариуцсан болон хамгаалах үүрэг бүхий этгээд гэх мэт) рүү амь биед нь аюултайгаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж довтолсон аливаа идэвхтэй үйлдлийг ойлгоно.

4. "Довтолсон" гэж бусдын эд хөрөнгийг өөрийн өмчлөлд авах зорилгоор илээр эсхүл гэнэдүүлэн (араас нь цохих, хоолой боох гэх мэт) өөр этгээд рүү хүч хэрэглэн халдсаныг хэлнэ.

Энэхүү халдлагад бие махбодийн хүчирхийлээс гадна хохирогчийн сэтгэцийн үйл ажиллагааг алдагдуулах, хордуулах буюу мансууруулах, сэтгээд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис зэргийг илээр болон нууцаар хэрэглэснийг хамааруулж үзнэ.

5. "Амь биед нь аюултайгаар хүч хэрэглэж" гэдэгт хохирогчийн эсэргүүцлийг

дарахад чиглэгдсэн бие махбодийн хүчирхийллийн аливаа үйлдэл хийснийг ойлгоно.

Хүч хэрэглэсэн тухайн үйлдлийн улмаас бусдын бие махбодид хор уршиг бодитойгоор учраагүй боловч хүч хэрэглэсэн арга нь (хоолой боох, хохирогчийн толгойг усанд удаан дүрэх, өндөр дээрээс түлхэх гэх мэт) хохирогчийн амь биед нь аюултай нөхцөл байдал бий болгохоор байсан бол дээрхи ойлголтонд хамааруулж үзнэ.

Түүнчлэн гэмт халдлагын улмаас хохирогчийн бие махбодид хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учирсан бол "амь биед нь аюултайгаар хүч хэрэглэсэн" гэдэгт хамаарна.

"Хүч хэрэглэхээр заналхийлж" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоолын 1.4-т зааснаар ойлгож хэрэглэнэ.

6. Бусдын эд хөрөнгийг "булаах" гэмт хэргийг үйлдэхэд хохирогчид ямар нэгэн хүч хэрэглэдэггүй бөгөөд үйлдэл төгсгөмц хохирогчоос зугтаах, холдох шинжтэй байдаг бол "дээрэмдэх" гэмт хэргийн хувьд хүчирхийлэл, довтолгоон нь тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүний үндсэн шинж нь болж, халдлагад өртөж байгаа этгээд рүү шууд чиглэсэн байдгаараа ялгагдана.

7. "Булаах" гэмт хэрэг нь бусдын эд хөрөнгийг хууль ёсны өмчлөгч болон эзэмшигч, хариуцсан эсхүл хамгаалах үүрэг бүхий этгээдээс өөртөө шилжүүлэн авснаар төгсдөг бол "дээрэмдэх" гэмт хэрэг нь бусдын эд хөрөнгийг авч чадсан эсэхээс үл хамаарч хүч хэрэглэсэн буюу хүч хэрэглэхээр заналхийлж довтолгоон хийснээр төгс үйлдэгдсэнд тооцогдоно.

8. "Дээрэмдэх" гэмт хэргийг үйлдэхдээ бусдын бие махбодид хөнгөн, хүндэвтэр гэмтэл учруулсан бол Эрүүгийн хуулийн 147 дугаар зүйлийн аль тохирох хэсгээр, хүнд гэмтэл учруулсан бол мөн зүйлийн 147.3-т зааснаар тус тус зүйлчилнэ.

Харин дээрмийн гэмт хэргийг үйлдэхдээ хүнийг санаатай алсан бол Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.7-д зааснаар зүйлчлэх бөгөөд энэ тохиолдолд мөн хуулийн 147 дугаар зүйлээр давхар зүйлчлэхгүй болохыг анхаарвал зохино.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	С.БАТДЭЛГЭР
ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН	
ТАНХИМЫН ТЭРГҮҮН	Д.БАТСАЙХАН
ШҮҮГЧ	Ч.ГАНБАТ

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

**ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 93 ДУГААР ЗҮЙЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ, САНАА СЭТГЭЛ НЬ ГЭНЭТ ХҮЧТЭЙ ЦОЧРОН ДАВЧИДСАН ҮЕД БУСДЫГ САНААТАЙ АЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ХҮНИЙГ САНААТАЙ АЛАХ ГЭМТ ХЭРГЭЭС ЯЛГАЖ, ЗӨВ ЗҮЙЛЧЛЭХ ТАЛААР**

Эрүүгийн хуулийн 93 дугаар зүйлийг нэг мөр ойлгох, санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчидсан үед бусдыг санаатай алах гэмт хэргийг хүнийг санаатай алах гэмт хэргээс ялгаж, зөв зүйлчлэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Нэг. Эрүүгийн хуулийн 93 дугаар зүйлийн зарим заалтыг дор дурдсанаар тайлбарласугай.

1.1. **"Хүчээр дарлагдсан"** гэдэгт бие махбодийн болон сэтгэл санааны аливаа хүчирхийлэлд өртсөнийг ойлгоно.

Энэ нь хүч хэрэглэн бие махбодид нь халдахаас гадна айлган сурдуулэх, заналхийлэх, хүсэл зоригийнх нь эсрэг үйлдэл хийлгэхээр албадах, тулган шаардах зэргээр үг яриа, үйл хөдлөл, үйлдлийн алианаар ч илэрч болно.

1.2. **"Хүндээр доромжлох"** гэж нийгэмд тогтсон хүмүүсийн хоорондын харилцааны болон өс суртахууны шаардлагын хэм хэмжээ, үндэсний зан заншил, уламжлалд харшилсан, тухайн хүний нэр төр, алдар хүндийг ичгүүр сонжуургүйгээр гутаасан үйлдлийг хэлнэ.

Энэ нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөрөнгө чинээ, эрүүл мэнд, гадна төрх, хөгжлийн бэрхшээлтэй болон гэр бүлийн байдалтай нь холбогдуулан үг, үйлдэл, бичгээр, дохио зангаагаар, зураг дүрсээр гутаасан зэргээр илэрнэ.

1.3. **"Хууль бус бусад үйлдэл"** гэдэгт гэм буруутай этгээд буюу түүний ойр дотных нь хүмүүсийн эрх, ашиг сонирхлыг ноцтой зөрчсөн, хүчээр дарлах, хүндээр доромжлохоос бусад хууль бус үйлдлүүдийг хамааруулан ойлгоно. Тухайлбал, эд хөрөнгийг нь авахаар далайлган сурдуулэх, устгах гэмтээх, хүний төрөлхийн болон жам есны эрхийг хязгаарлах, хориглох, дураараа аашлах, гүтгэх гэх мэт.

1.4. **"Ойр дотны хүмүүс"** гэдэгт Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.11-д заасан гэр бүлийн гишүүд хамаарна.

1.5. **"Хүнд хор уршиг учирсан"** гэдэгт хохирогчийн хууль бус үйлдлийн улмаас эд хөрөнгийн хувьд хохирол учирсан, гэм буруутай этгээд болон түүний гэр бүлийн гишүүд нь сэтгэцийн болон бусад хүнд өвчнөөр өвчилсөн, бие эрхтэнд нь хүнд гэмтэл учирсан буюу амь нас хохирсон зэрэг үр дагавар бий болсныг ойлгоно.

1.6. **"Хүнд хор уршиг учирч болох байсан"** гэдгийг хохирогчийн хууль бус үйлдлийн улмаас тухайн нөхцөл байдалд ямар үр дагавар гарах байсныг шүүх хэрэгт авагдсан болон шүүх хуралдаанаар ханан хэлэлцсэн нотлох баримтын хэмжээнд үнэлж дүгнэнэ.

1.7. **"Санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчидсан"** гэж хохирогчийн хууль бус үйлдлийн улмаас сэтгэл санааны гэнэтийн цочролд хоромхон зуур автаж, сэтгэхүйн хэвийн байдал алдагдан, өөрийн үйл ажиллагааг удирдан жолоодох, өөртөө хяналт тавих чадваргүй болсон байдлыг хэлнэ.

Энэхүү нөхцөл байдал нь хохирогчийн зүгээс хийсэн нэг эсхүл хэд хэдэн удаагийн хууль бус үйлдлийн улмаас үүссэн байж болно.

1.8. Санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчидах нь сэтгэцийн өвчин биш тул энэ тохиолдолд гэмт этгээдийг хэрэг хариуцах чадваргүй гэж үзэхгүй.

Харин гэмт этгээд хэргийнхээ үйлдлийг тайлбарлах, түүнийг хариуцах чадвартай эсэхэд эргэлтэ төрөөл түүний сэтгэцийн байдлын талаар дүгнэлт гаргуулахаар сэтгэцийн эмгэг судлалын шинжилгээ хийлгэж болно.

1.9. Санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчидсан үед бусдыг санаатай алсан хэргийн талаар мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах, шүүхээр хянан шийдвэрлэхэд хохирогчийн зүгээс хүчээр дарласан, хүндээр доромжилсон, эсхүл хууль бус бусад ямар үйлдэл хийсэн, эдгээрийн улмаас гэм буруутай этгээдэд өөрт нь буюу ойр дотных нь хүмүүст ямар хор уршиг учирсан, эсхүл учирч болох байсан зэргийг заавал нотолсон байвал зохино.

**Хоёр. Санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчидсан үед бусдыг санаатай алах хэргийг хүнийг санаатай алах гэмт хэргээс ялгаж, зөв зүйлчлэх талаар**

2.1. Санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчидсан үед бусдыг санаатай алах гэмт хэргийн сэдэлт нь хохирогчийн хууль бус үйлдэлтэй шууд холбоотой байдаг бол хүнийг санаатай алах гэмт хэргийн бүрэлдэхүүний хувьд энэ нь субъектив талын заавал байх шинж биш болохыг анхаарвал зохино.

2.2. Санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчдсан үед бусдыг алах санаа гэнэт, хоромхон зуур төрдөг бол хүнийг санаатай алах гэмт хэргийн хувьд гэмт этгээд өөрийн үйлдлийн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаж, түүний улмаас нийгэмд аюултай хор уршиг учрах нь зайлшгүй, эсхүл учрах боломжтойг урьдчилан мэдсэн атлаа хүсэж үйлдсэн буюу уг хор уршигийг хүсээгүй боловч түүнд зориуд хүргэсэн шууд болон шууд бус санаатай байдгаараа ялгагдана.

2.3. Өс хонзонгоор хүнийг санаатай алах гэмт хэрэг нь урьдчилан бэлтгэж, төлөвлөсөн байдаг бол санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчдсан үед бусдыг санаатай алах гэмт хэргийн бүрэлдэхүүний хувьд ийм шинжийг агуулдаггүйгээрээ ялгагдана.

2.4. Хүнийг санаатай алах гэмт хэрэг үйлдсэнээс хойш санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчдсан үедээ бусдыг санаатай алсан бол Эрүүгийн хуулийн 91, 93 дугаар зүйлээр давхар зүйлчлэх бөгөөд энэ тохиолдолд хүнийг санаатай алах гэмт хэргийг давтан үйлдсэн гэж үзэхгүй.

2.5. Эрүүгийн хуулийн 40 дүгээр зүйлд заасан аргагүй хамгаалалтыг өөрийн үйл ажиллагааг бүрэн удирдаж, өөртөө хяналт тавьж хийдэг бол санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчдсан үед сэтгэхүйн хэвийн байдал алдагдаж, дээр дурдсан чадваргүй болдгоороо ялгагдана.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ**
**С.БАТДЭЛГЭР**
**ШҮҮГЧ**
**Б.ДОРЖГОТОВ**

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

### ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Газрын тухай хуулийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь.

1. Газрын тухай хуулийн /цаашид хуулийн гэх/ зарим заалтыг дараах байдлаар тайлбарласугай

1.1. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасан **"...ашиглуулж болно ..."** гэдгийг Сууц өмчлөгчдийн холбоо нь орчны газрыг зөвхөн энэ зүйлд заасан зориулалтаар л ашиглах бөгөөд тухайн газрыг бусдад ашиглуулах, ашиглах зөвшөөрөл олгох, тусуулах, барьцаалах, газрын ашигтай чанарыг гаргаж хэрэглэх эрх эдлэхгүй гэж ойлгоно.

1.2. Хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасан **"... газрын төлөв байдлыг илэрхий доройтуулсан ..."** гэж газрын төлөв байдлын урьдах хянан баталгааны үзүүлэлтүүдийг бууруулсан, хөрсийг хордуулсан, бохирдуулсан, үржил шимгүй болгосон зэргийг хэлэх бөгөөд энэ нь хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3-д зааснаар эрх олгогдсон мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр батлагдсан байвал зохино.

1.3. Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.3, мөн зүйлийн 21.3.2-т тус тус заасан **"... Инженерийн шугам сүлжээ бүхий болон сүлжээнд холбогдохоор төлөвлөгдсөн газар ..."** гэдэгт аймаг, нийслэлийн төвийн нутаг дэвсгэрт барьж байгуулагдсан, түүнчлэн газар зохион байгуулалтын

ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий, хэсэгчилсэн төлөвлөгөөнд барьж байгуулагдахаар төлөвлөгдсөн, дулаан, уур, цэвэр, бохир ус, цахилгаан эрчим хүч, холбоожуулалт, радио дохиоллын холболтын эх үүсвэрээс Барилгын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан "барилгын техникийн нөхцөл"-ийг авч болох газар хамаарна.

Харин инженерийн шугам сүлжээ бүхий болон сүлжээнд холбогдохоор төлөвлөгдсөн газарт хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан **"зам, шугам сүлжээний газар"** хамаарахгүй.

1.4. Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.1, 21.4.1 болон 21.2.3, 21.3.2-т тус тус зааснаар сум, дүүргийн Засаг даргын саналыг авсан бол тухайн асуудлаар тэдгээрийн саналыг дахин авах шаардлагагүй.

1.5. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.5-д заасан **"...нөхөн сэргээсэн ..."** гэдэгт сонирхогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ашиглалтгүй орхигдсон газрын эвдрэл, элэгдлийг **"нөхөн сэргээх"** төсөл, төлөвлөгөө боловсруулан аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба, сумын газрын даамал болон Засаг даргатай урьдчилан тохиролцож, гэрээ хийсний үндсэн дээр хөрсний үржил шимийг сайжруулсан, ургамлан нөмрөгийг сэргээсэн, газрын гадаргууг засаж тэгшилсэн, хордолт, бохирдлыг цэвэрлэсэн зэргийг ойлгоно.

Газрыг нөхөн сэргээсэн эсэхийг газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтээр тодорхойлно.

Харин газрыг тариаланд эргүүлж ашиглах болон хадлан, бэлчээрийн зориулалтаар нөхөн



сэргээсэн бол Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журамд залсан болзлыг хангасан байвал зохино.

1.6. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасан хугацаа нь мөн хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д заасан хугацаатай адил байна.

Хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д газрыг 15-60 жил хүртэл хугацаатайгаар эзэмшүүлэхээр заасан тул газар эзэмшүүлэх хугацааг 15 жилээс доош хугацаагаар тогтоохгүй.

Мөн зүйл, хэсэгт заасан "... нэг удаад сунгах хугацаа 40 жилээс илүүгүй байна..." гэдгийг газар эзэмшигч газар эзэмших эрхийн хугацааг хэдэн ч удаа сунгуулж болох бөгөөд зөвхөн нэг удаад сунгах хугацааны дээд хэмжээ 40 жилээс хэтрэхгүй байна гэж ойлгоно.

1.7. Хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1-д заасан "... тосовт байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй газар ..." гэж Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т заасан байгууллагын хуулиар хүлээглэсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь зориулан эрх бүхий албан тушаалтан, байгууллагаас газрын байршил, зориулалт, хэмжээг зааж эзэмшүүлсэн болон эзэмшүүлэх газрыг хэлнэ.

1.8. Хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4-т зааснаар газрыг бусдад шилжүүлэх тохиолдолд мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.3, 38.4-т заасан журмыг баримтлан, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т заасны дагуу Засаг дарга захирамж гаргана.

Мөн зүйл, хэсэгт заасны дагуу газрыг бусдад барьцаалах тохиолдолд Засаг дарга албан бичгээр зөвшөөрөл олгох бөгөөд үүний дараа хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасан эрх бүхий албан тушаалтан, байгууллага бүртгэл, тэмдэглэл хийнэ.

1.9. Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1-д заасан "... удаа дараа ..." гэдгийг мөн зүйлийн

40.1.2-40.1.6-д зааснаас бусад хэлбэрээр хууль тогтоомж, гэрээний нөхцөл, болзлыг 2 буюу түүнээс дээш удаа зөрчсөн байхыг ойлгоно.

Нэг зөрчлийг давтан эсхүл өөр өөр зөрчил гаргасны аль аль нь дээрх ойлголтод хамаарна.

Мөн зүйл, хэсэгт заасан "... ноцтой зөрчил..."-ийг газар эзэмшүүлэх гэрээний галуул гэрээний нөхцөл, болзлын онцлогтой холбогдуулан харилцан тохиролцон тогтоож, уг зөрчлийн тохиолдол бүрийг гэрээнд нэрлэн заасан байвал зохино.

1.10. Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6-д заасан "... хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ..." гэдгийг гэнэтийн давагдашгүй хүчний эсхүл байгалийн тогтолцооны өөрчлөлтөөс тухайн газарт нь эвдрэл, элэгдэл, цөлжилт бий болсон, бусдын хууль бус үйлдэл зэрэг газар эзэмшигчээс хамаарах шалтгаан байхгүй байсныг ойлгоно.

Мөн зүйл, хэсэгт заасан "... зориулалтын дагуу газраа 2 жил дараалан ашиглаагүй" гэдгийг газар эзэмшүүлэх тухай гэрээ хийгдсэнээс хойш хуанлийн бүтэн 2 жилийн дотор газар эзэмшигч нь тухайн газар дээрээ гэрээнд заасан нөхцөл, болзол, зориулалтын дагуу тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлээгүй /барилга, байгууламж, зам талбай бариагүй, тариалан эрхлээгүй г. м/ байхыг ойлгоно.

1.11. Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т заасан "... мэдэгдэнэ ..." гэдэг нь Засаг даргын захирамж эсхүл түүний утгыг бүрэн илэрхийлсэн мэдээллийг эрхийн гэрчилгээ эзэмшиж байсан буюу барьцаалсан этгээдэд бичлэн гардуулах, түүний оршин суугаа болон ажлын газрын хангаар баталгаат шуудангаар хүргүүлэх, утас, факс, e-майль, цахилгаан зэргээр холбогдох этгээдэд мэдэгдэж, түүнийгээ баталгаажуулсныг хэлнэ.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

Д.ПУНЦАГ

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг тус тус удирдлага болгон **Улсын Дээд шүүхээс ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн (цаашид хууль гэх) 10 дугаар

зүйлийн 10.1.8.-д заасан "онцгой нөхцөл байдал үүссэн" гэдэгт сонгуулийг зохих ёсоор явуулахад урдчилан төлөвлөнгүй бөгөөд төлөвлөх боломжгүй, энэ зүйлийн бусад заалтад туссанаас гадна нэмэлт зардал, хөрөнгө зарцуулагдах зайлшгүй шаардлага бий болсныг ойлгоно.

2. Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1., 19.2-т зааснаар тухайн хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувь оролцсон хуралдаанаас



хорооны эрх хэмжээний асуудлаар гарсан шийдвэр хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн санагд үндэслэгдсэн бол энэ шийдвэрийг баталгаажуулсан тогтоолд хорооны дарга, эсхүл нарийн бичгийн дарга гарын үсэг зурахаас татгалзах эрхгүй.

Мөн зүйлийн 19.3.-т зааснаар тойрог, салбар, хэсгийн хороодын тогтоолд тухайн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурах үүрэгтэй бөгөөд дээдэрийн хэн нэг нь гарын үсэг зураагүйгээр тогтоол хүчингүй, эсхүл хүчин төгөлдөр бус болохгүй.

Харин хуралдаанд оролцсон гишүүдийн тоо хүрэлцээгүй, эсхүл тухайн хорооны бүрэн эрхэд хамааралгүй асуудлыг шийдвэрлэсэн, эсхүл бүрэн эрхийн асуудлыг олонхийн саналаар шийдвэрлээгүй бол тогтоолд хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурсан байсан ч тухайн шийдвэрийг хүчинтэй гэж үзэхгүй.

Хорооны тогтоолд гарын үсэг зурах нь уг шийдвэрийн хүчинтэй байдлын, эсхүл түүнийг хүлээн зөвшөөрсний илэрхийлэл биш, харин гарсан шийдвэрийн агуулгыг баталгаажуулж буй явдал тул хуульд заасан журмын дагуу гарсан хорооны шийдвэртэй дарга, эсхүл нарийн бичгийн дарга санал нийлээгүй байх нь гарын үсэг зурах үүргээ биелүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

3. Хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.-д заасан "тухайн хэсэгт байнга... оршин суугаа сонгогч" гэдэгт Иргэний бүртгэлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1., Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.11.-д зааснаар хүн амын тооллогын дагуу баг, хорооны тодорхой хаягт бүртгэлтэй иргэнийг хэлнэ.

Бүртгэлтэй газраа биш харин өөр газар 180 хоног ба түүнээс доош хугацаагаар оршин сууж байгаа явдал тухайн иргэнийг бүртгэлтэй газрын байнгын оршин суугч биш гэж үзэх үндэслэл болохгүй.

Бүртгэлтэй газраас өөр газар оршин суудаг иргэн байнга оршин суугчийн хувьд бүртгэлийнхээ хаягаар сонгуульд оролцох, эсхүл бүртгэлгүй газар түр оршин суугчийн хувьд сонгуульд оролцох нь түүний эрх бөгөөд харин сонгуулийн нэг хэсэгт, сонгогчдын нэрийн нэг жагсаалтад давхардал, будлиангүй бүртгүүлэх нь түүний үүрэг болно.

Мөн зүйлийн "... түр оршин суугаа сонгогч" гэдэгт тухайн баг, хороонд бүртгэлгүй боловч 180 хоног ба түүнээс доош хугацаагаар тухайн баг, хороонд оршин сууж байгаа иргэнийг хэлнэ.

Түр оршин суугч нь өөрийн байнгын оршин суух бүртгэлтэй газар сонгогчийн нэрийн жагсаалтад ороогүй, эсхүл бүртгэлээс хасагдсан тохиолдолд түүнийг бүртгэлгүй газар түр оршин суугаа сонгогч гэж үзнэ.

Түр шилжин суурьшиж буй иргэн нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу байнга оршин суудаг нутаг дэвсгэрийн бүртгэлийн дэвтэрт "түр эзгүй" гэсэн тэмдэглэл, түр шилжин суурьших

тухай тодорхойлолт тус тус хийлгэж, түр оршин суух нутаг дэвсгэрийн сум, дүүргийн Засаг даргад 7 хоногийн дотор бүртгүүлж, түр оршин суух үнэмлэх авсан байвал зохино.

4. Хуулийн 30 дугаар зүйлийн 30.10.7.-д заасан "бусдыг төлөөлүүлэх" гэдэгт дэмжигч-сонгогчоор бүртгэгдсэн этгээдийн өмнөөс өөр хүнээр гарын үсэг зуруулах, гэр бүлийн гишүүд, садан төрөл, найз нөхөд, танилуудын өмнөөс хэн нэгнээр нэрийг нь дэмжигч-сонгогчоор бичүүлэх зэргээр сонгогчийг өөрийнх нь хүсэл зоригтоос гадуур бусдаар дамжуулан дэмжигчээр бүртгүүлэхийг ойлгоно.

Мөн зүйлийн "хүч хэрэглэх", "заналхийлэх" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоолын 1.4.-т зааснаар буюу "бие махбодийн хүчирхийлэл хийхэд чиглэгдсэн аливаа зорилготой үйлдэл", "бусдыг айлган сүрдүүлэх зорилгоор хийсэн, идэвхтэй үйлдлээр илрэх сэтгэл санааны хүчирхийлэл" гэж тус тус ойлгоно.

Энэ зүйлийн "хуурч мэхлэх" гэж Улсын Дээд шүүхийн 2006 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 51 дүгээр тогтоолын 2-т зааснаар буюу "үг болон үйлдлээр бодит байдлыг гуйвуулах, нууц дарагдуулах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох"-ыг хэлнэ.

Мөн зүйлийн "эд мөнгөөр татах" гэдэгт мөнгө, эд хөрөнгө өгөх, аливаа ажил үйлчилгээг төлбөргүй үзүүлэх зэргээр бусдын хүсэл зоригийн илэрхийлэлд нөлөөлөхийг ойлгоно.

Энэ зүйлийн "сонгуулийн эрхгүй этгээдээр гарын үсэг зуруулах" гэж хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2.-т заасан арван найман насанд хүрээгүй, эрх зүйн бүрэн чадамжгүй буюу сонгуулийн эрх бүхий иргэн гэж үзэхгүй этгээдийг дэмжигч-сонгогчоор бүртгэж, түүгээр гарын үсэг зуруулсан байхыг хэлнэ.

Мөн зүйлийн "гарын үсэг хуурамчаар үйлдэх" гэдэгт бүх төрлийн арга хэрэглэн (өөрөө, эсхүл өөр этгээдээр үйлдүүлэх, техник хэрэгсэл ашиглах г.м.) бусдын гарын үсгийг дуурайлгаж буюу хуулбарлаж, эсхүл зохиож зурахыг ойлгоно.

5. Хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.-д заасан "хүндээр өвчилсон" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2002 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 71 дүгээр тогтоолын 8-д тайлбарлэснаар буюу "хөдөлмөрийн чадвараа алдах, эмнэлэгт хэвтэх, хэвтрийн дэглэм зайлшгүй сахиу шаардлагатай байх, мэс засалд орох, эмчийн хяналтан дор тууштай эмчилгээ хийлгэх" зэргээр сонгуульд нэр дэвшигчээр оролцох боломжгүй болохыг ойлгох бөгөөд энэ байдал нь эмнэлгийн тодорхойлолтоор батлагдсан байвал зохино.

Мөн зүйлийн "гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан" гэдэгт эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн нь хангалттай нотлох баримтаар нотлогдож, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэл, журмын



дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор үг этгээдийг яллагдагчаар татах тухай тогтоол үйлдсэн байхыг ойлгоно.

Нэр дэвшигч хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3.-т заасан "ялгүй байх" шаардлагыг хангасан нь хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.5., 30.4.-т зааснаар цагдаагийн төв байгууллагын тодорхойлолтоор батлагдсан бөлсөн санал авахаас 10-аас доошгүй хоногийн өмнө нэр дэвшигч ийнхүү яллагдагчаар татагдсан бол нам, эвсэл мөн зүйлийн 31.4.-т заасан хугацаанд түүнийг татан гаргаж, өөр хүний нэрийг дэвшүүлэх эрхтэй.

Харин санал авах өдөр хүртэл 10-аас доош хоног үлдсэн байдад нэр дэвшигч яллагдагчаар татагдсан тохиолдолд нам, эвсэл нэр дэвшигчийг татан гаргах ба оронд нь өөр хүний нэрийг дэвшүүлэх эрхгүй болно.

Нэр дэвшигчийг яллагдагчаар татах асуудлыг хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.-т заасны дагуу "гэмт үйлдлийнх нь явцад хойшлуулагшгүй баривчлахаас бусад тохиолдолд" эвххон тойргийн хорооны зөвшөөрөлтэйгээр шийдвэрлэнэ.

**6** Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.-т заасан "нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан" гэдэгт нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэхдээ хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4.5.-д зааснаар Сонгуулийн Ерөнхий хороонд ирүүлсэн баримт бичигтээ тусгасан төв байгууллагын бүрэлдэхүүн багтахаас гадна түүний салбар, бүтцийн байгууллагын бүрэлдэхүүн, түүнчлэн эдгээр байгууллагуудаас томилогдсон этгээдийн аль аль нь хамаарна.

Мөн зүйлд заасан "ухуулагч" гэдэгт нам, эвслээс нэр дэвшигчийн болон тухайн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг сонгогчидод тайлбарлан таниулах, нэр дэвшигчийн талаарх мэдээллийг сонгогчидод хүргэх, нэр дэвшигчээс сонгогчидтой хийх уулзалтыг зохион байгуулах үүрэг бүхий, тухайн нам, эвслээс томилогдсон этгээдийг ойлгоно.

Энэ зүйлд заасан "шадар туслагч" нь зөвхөн бие даан нэр дэвшигчийн сонгуулийн ажиллагаанд туслах үүрэгтэй оролцдог бөгөөд 200 сонгогчид нэг шадар туслагч ажиллана.

Харин "нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан" болон "ухуулагч" нь нам, эвслээс нэр дэвшигчийн сонгуулийн ажиллагаанд туслах үүрэгтэй оролцдог тул нэр дэвшигчдийн тэгш байдлыг хангах үүднээс 200 сонгогчид нэг ажилтан, эсхүл нэг ухуулагч ажиллана.

Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан нэр дэвшигчийн ухуулагчаар ажиллах, нэр дэвшигчийн ухуулагч үг байгууллагын ажилтан байх боломжтойн адил нэр дэвшигчид туслах үүрэг бүхий үг хоёр этгээд заавал давхардсан үүрэгтэй байх шаардлагагүй болно.

**7.** Хуулийн 37 дугаар зүйлд заасан сонгуулийн сурталчилгаа явуулах зохицуулалтыг доорх байдлаар тайлбарласугай.

**7.1.1.** Энэ зүйлийн 37.4.-т заасан "хэвлэлийн хуудас"-ын тодорхойлолт, хэмжээ, загварыг Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1., 7.1.7.-д зааснаар Сонгуулийн Ерөнхий хороо тогтооно.

**7.1.2** Мөн зүйлийн 37.11.1.-д зааснаар "сонгууль зарласнаас хойш нэр дэвшигчийг бүртгэж, үнэмлэх олгох хүртэлх хугацаанд сонгуулийн аливаа хэлбэрийн сурталчилгаа явуулах"-ыг хориглосон тул дээрх хугацаанд энэ хууль болон Зар сурталчилгааны тухай хуульд заасан мэдээлэл түгээх, ухуулга хийх бүхий л арга, хэлбэрийн ил, далд сурталчилгаа явуулж болохгүй.

**7.1.3** Энэ зүйлийн 37.11.14.-т зааснаар "...сонгуулийн бус олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах"-ыг хориглосон нь сонгуулийн бэлтгэл ажиллагааны хүрээнд зайлшгүй хийгдэх ажилд орохгүй, энэ хуулиар хориглосон, эсхүл зөвшөөрөгдөөгүй, олныг хамарсан бүхий л арга хэмжээнд хамааралтай болно.

**7.1.4.** Мөн зүйлийн 37.11.16.-д зааснаар "төрийн жинхэнэ албан хаагчийг сонгуулийн сурталчилгаанд аливаа хэлбэрээр татан оролцуулах"-ыг хориглосон тул Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.2., 3.3.3.-т заасан төрийн захиргааны болон тусгай албан хаагчийг сонгуулийн сурталчилгааны бүхий л ажиллагаанд оролцуулж болохгүй.

**7.1.5** Энэ зүйлийн 37.11.18.-д зааснаар "сонгогчдын санал худалдан авахад чиглэсэн бусад аливаа үйлдэл, үйл ажиллагаа явуулах"-ыг хориглосон зохицуулалтад мөнгө, эд хөрөнгө өгөх, амлах, дамжуулах, зуучлах, аливаа ажил, үйлчилгээг төлбөргүй үзүүлэх зэрэг төрөл бүрийн арга, хэлбэрээр сонгогчийн санал өгөх эрхийг өөрийн сонирхолд нийцүүлж, тодорхой нэр дэвшигчид санал өгүүлэх зорилгоор явуулж буй бүхий л ажиллагааг хамааруулан ойлгоно.

**7.1.6** Мөн зүйлийн 37.14.3.-т зааснаар сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглосон байгууллагад

"хүмүүнлэгийн" буюу ядуу, нийгмийн хамгаалалтгүй, байгалийн гамшиг болон бусад онцгой учралд нэрвэгдсэн хүн амд эмнэлгийн хийгээд нийгэмшлийн тусламж үзүүлэх, байгалийн гамшигын ба бусад онцгой учралын хор уршгийг ариггах зорилго бүхий олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын төрийн бус байгууллага;

"буяны" буюу тусламж шаардлагатай хүмүүст туслах ба нийтийн сайн сайхны төлөө ажилладаг олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын төрийн бус байгууллага;

"шашны" буюу Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар шашны зан үйл, хурал ном, боловсролын ажлыг эрхлэн гүйцэтгэж буй албан ёсны зөвшөөрөл бүхий хийд, сүм, дацан, төв болон тэдгээрийн удирдах байгууллагууд тус тус хамаарна.

**8** Сонгуульд санал өгөх талаарх энэ хуулийн 47 дугаар зүйлийн зарим зохицуулалтыг

доорх байдлаар тайлбарласугай:

**8.1.** Сонгогч саналаа өгөхдөө энэ зүйлийн 47.3 -т зааснаар "саналын хуудсанд бичигдсэн нэр дэвшигчдийн дотроос өөрийн сонгохыг хүсч байгаа, тухайн тойрогт ногдсон мандатын тоотой тэнцэх нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэр, нэрийн өмнөх дугаарыг" дугуйлна.

Энэ нь Монгол Улсын иргэнд Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 9 дэх хэсэгт зааснаар олгогдсон "төрийн байгууллагад сонгох" үндсэн эрхийн хэрэгжилт тул сонгогч нь нэр дэвшигч нарсаас хэнийг нь ч сонгохыг хүссээгүй бол аль ч дугаарыг дугуйлахгүй байх эрхтэй бөгөөд энэ тохиолдолд түүнийг санал хураалтад оролцсон гэж үзэхээс гадна саналын хуудсыг нь хүчинтэйд тооцоо.

Түүнчлэн сонгохыг хүсч байгаа нэр дэвшигчийн тоо тухайн тойрогт ногдсон мандатын тооноос бага байвал сонгогч уг тооноос дутуу хэмжээгээр зөвхөн өөрийн сонгохыг хүссэн нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугаарыг дугуйлах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд түүний саналын хуудас мөн хүчинтэй байна.

Харин тухайн тойрогт ногдсон мандатын тооноос илүү дугуйлсан бол саналын хуудас хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.3.-т зааснаар хүчингүйд тооцогдоно.

"Тухайн тойрогт ногдсон мандатын тоотой тэнцэх нэр дэвшигчийн" төлөө саналаа өгөх нь энэ хэмжээний нэр дэвшигчдийг заавал сонгох сонгогчийн үүрэг биш тул уг зохицуулалтыг сонгогчийн сонгох эрхээ хэрэгжүүлэхэд баримтлах дээд хязгаар гэж ойлгоно.

**8.2.** Энэ зүйлийн 47.7 -д заасан "итгэмжилсэн хүн" гэж сонгогчийн өөрийн хүсэл зоригийн дагуу тухайлан сонгож, санал авах байранд дагуулж ирсэн, санал өгөхөд нь унших, бичих хэлбэрээр туслалцаах үзүүлэх чадвартай, насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай иргэнийг хэлнэ. Сонгогчийн итгэмжилсэн хүний эрх зүйн байдлыг түүний иргэний үнэмлэхээр тодорхойлно.

**8.3.** Мөн зүйлийн 47.14 -т заасан "сонгогч түр шилжин явна" гэсэнд Иргэний бүртгэлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 -д зааснаар байнга оршин сууж байгаа засаг захиргааны нэг нэгжээс нөгөөд 180 хоног ба түүнээс доош хугацаагаар оршин суух буюу түр шилжин суурьшихыг ойлгохоос гадна гадаад болон дотоодод албан томилолт, эмчилгээ, сургалтад явах зэргээр түр хугацаагаар байнгын бүртгэлтэй газраас өөр газар очих шаардлагын улмаас санал хураах өдөр байнгын оршин суух газрын хэсэгт саналаа өгөх боломжгүй болох нөхцлийг хамааруулна.

**8.4.** Энэ зүйлийн 47.15 -д заасан "урдчилан санал өгөх" зохицуулалт зөвхөн мөн зүйлийн 47.14 -т заасан тохиолдолд хамааралтай болно.

**9.** Саналын хуудсыг хүчингүйд тооцох талаарх энэ хуулийн 49 дүгээр зүйлийн зарим

зохицуулалтыг доорх байдлаар тайлбарласугай:

**9.1.** Энэ зүйлийн 49.1.3.-т "энэ хуульд зааснаас өөр тэмдэглэл хийсэн" гэдэгт сонгогч саналаа илэрхийлэхдээ саналын хуудсанд хуулийн 47 дугаар зүйлийн 47.3 -т зааснаар нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугаарыг дугуйлахаас өөрөөр буюу сонгох хүний нэрийг бүхэлд нь дугуйлах, нэрийнх нь өмнө нэмэх, цагт, сум, од г.м. тэмдэг тавих, сонгохыг хүссээгүй хүний нэрийг, эсхүл өмнөх дугаарыг дарах, хасах тэмдэг тавих зэргээр тэмдэглэл үйлдсэн байхыг ойлгоно.

**9.2.** Сонгогч саналаа өгөхдөө алдаа гаргаж, саналын хуудсанд буруу тэмдэглэл хийсэн бөгөөд хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 -т зааснаар саналын хуудас дахин авах эрхээ хэрэгжүүлэхгүйгээр өөрийн тэмдэглэгээний алдааг энэ журмаас өөрөөр буюу баллах, дарах, сум гатах, бичилт хийх зэргээр залруулсныг "нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугаарыг өөрчлөх" зөрчилд хамааруулан үзнэ.

**10.** Санал хураалтыг хүчингүйд тооцох тухай хуулийн 52 дугаар зүйлийн зарим зохицуулалтыг доорх байдлаар тайлбарласугай:

**10.1.** Энэ зүйлийн 52.1.1.-д заасан "байгалийн гамшиг" гэдэгт хүний үйл ажиллагаанаас үл хамаарах аюулт үзэгдлийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд үнс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрах буюу байгалийн хүчний үйлчлэлийн үр дагавар болох онцгой нөхцөл байдал, "гоц халдварт өвчин" гэдэгт богино

хугацаанд тархаж, хүн, малын эрүүл мэндэд хохирол учруулах аюул бүхий, хорно дээр тогтоох зайлшгүй шаардлагатай халдварт өвчин тус тус хамаарна.

**10.2.** Мөн зүйлийн 52.1.3.-т заасан "сонгогчийн санал, санал хураалтын дүнг гажуудуулахад хүргэсэн" гэдэгт сонгогчийн саналаа чөлөөтэй өгөх эрхэд хөндлөнгөөс хууль бусаар аливаа хэлбэрээр нөлөөлсний үр дүнд түүний саналыг хүсэл зоригийн жинхэнэ илэрхийлэл, түүнчлэн санал хураалтын эцсийн дүнг бодит байдалд нийцсэн дүнг гэж тус тус үзэх боломжгүй болохыг ойлгоно.

**10.3.** Хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.3.-т заасан "тойргийн сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөхөөр байвал" гэдэгт энэ зүйлийн 53.1.1., 53.1.2.-т заасан нөхцөл байдал үүсэхийг ойлгохоос гадна сонгуулийн тухайн тойрогт сонгогдох хүний тоо мандатын тоонд хүрэхгүй байх, нэр дэвшигчийн төлөө өгсөн нийт саналын дүн өөрчлөгдөж, сонгогдох эрхээд нөлөөлөхүйц болох зэрэг байдлыг хамааруулна.

**11.** Хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 -т заасан "тодорхойлолт"-ыг Улсын Дээд шүүх мөн зүйлийн 30.2.4.-т зааснаар нэр дэвшигчийн мэдүүлгийг

үндэслэж түүний үнэн зөв байдлыг хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.1., 27.4.2-т тодорхойлсон хүрээнд Сонгуулийн Ерөнхий хорооноос баталсан маягтын дагуу гаргаж өгнө.

Хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.1., 27.4.2-т заасан **"шүүхийн шийдвэр"** нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хуулийн хүчин төгөлдөр болсон буюу түүний талаар дахин гомдол гаргах, маргааны зүйлийн талаар шүүхэд нэхэмжлэл гаргах, тухайн үйл баримт, эрх зүйн харилцааны талаар өөр ажиллагаанд маргах, шийдвэрийг дээд шатны шүүхээс өөрчлөх, хүчингүй болгох тус тус боломжгүй болсон байхаас гадна үг шийдвэрийг заавал биелүүлэх үүрэг иргэн, хуулийн этгээдэд үүссэн байна.

Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон зээл, батлан даалтын болон бусад гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өр, татварын өр төлбөрийг бүрэн төлсөн эсэх байдлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас авлагаа авч тодорхойлно.

**12.** Хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3.-т заасан **"ялгуйл байх"** гэдгийг Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд заасан **"ялгуйд тооцох"**, **"ялгуй болох"** гэсэн ойлголтуудтай адилтгаж үзэх үндэслэлгүй тул үүнийг өмнө нь огт **"ял шийтгүүлж байгаагүй"** гэж ойлгон хэрэглэнэ.

**13.** Сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн аливаа үйлдэл, үйл ажиллагаанд гомдол гаргах журмыг тодорхойлсон энэ хуулийн зохицуулалтыг доорх байдлаар тайлбарласугай.

**13.1.** Хуулийн 57 дугаар зүйлийн 57.1.-д зааснаар **"гомдлыг холбогдох сонгуулийн хороонд гаргана"** гэснийг хуулийн 19, 21 дүгээр зүйл, 57 дугаар зүйлийн 57.5.-д тус тус зааснаар хэрэгжүүлнэ.

**13.2.** Мөн зүйлийн 57.5., 19 дүгээр зүйлийн 19, 10.-т зааснаар гомдлыг шийдвэрлэсэн Сонгуулийн Ерөнхий хорооны шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар гомдол, хүсэлтийг Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын дагуу Үндсэн хуулийн цэцэд гаргана.

Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 2/02 дугаар дүгнэлт Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан **"Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах"** Монгол Улсын иргэний үндсэн эрхийг хязгаарлахгүй тул Сонгуулийн Ерөнхий хорооны шийдвэр Үндсэн хуулиас бусад хуулийг, Үндсэн хуулиар Монгол Улсын иргэнд олгогдсон сонгох, сонгогдох эрхээс бусад эрхийг зөрчсөн талаарх гомдлыг Сонгуулийн Ерөнхий хорооны оршин байгаа дүүргийн шүүхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр бүлэгт заасан журмын дагуу гаргана.

**13.3.** Хуулийн 21 дүгээр зүйлд заасан тойргийн хорооны шийдвэрт тухайн тойргийн хороог харьяалах сум буюу сум дунд, дүүргийн шүүхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр бүлэгт заасан журмын дагуу гомдол гаргана.

**14.** Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдэд захиргааны хариуцлага ногдуулах асуудлаарх энэ хуулийн зохицуулалтуудыг доорх байдлаар тайлбарласугай.

**14.1.** Захиргааны хариуцлагын тухай хуулийн 53 дүгээр зүйлийн 1-д зааснаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдэд захиргааны хариуцлага ногдуулах асуудлыг Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.-т зааснаар сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч хянан шийдвэрлэнэ.

**14.2.** Хуулийн 5 дугаар зүйлийн 5.6., 6 дугаар зүйлийн 6.7., 9 дүгээр зүйлийн 9.4., 10 дугаар зүйлийн 10.5., 14 дүгээр зүйлийн 14.8., 14.9., 19 дүгээр зүйлийн 19.14., 20 дугаар зүйлийн 20.12., 22 дугаар зүйлийн 22.6., 23 дугаар зүйлийн 23.6., 30 дугаар зүйлийн 30.19., 35 дугаар зүйлийн 35.4., 35.5., 36 дугаар зүйлийн 36.4., 37 дугаар зүйлийн 37.17., 37.18., 38 дугаар зүйлийн 38.4., 40 дүгээр зүйлийн 40.7., 41 дүгээр зүйлийн 41.9., 42 дугаар зүйлийн 42.8., 43 дугаар зүйлийн 43.6., 44 дүгээр зүйлийн 44.12., 45 дугаар зүйлийн 45.9., 46 дугаар зүйлийн 46.9., 47 дугаар зүйлийн 47.19., 48 дугаар зүйлийн 48.11., 52 дугаар зүйлийн 52.6.-д заасан зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг холбогдох сонгуулийн хороонд гаргана. Үг гомдол, мэдээлэл, үйл баримтыг үндсэн холбогдох сонгуулийн хороод Захиргааны хариуцлагын тухай хуулийн 11-16 дугаар зүйлд зааснаар зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж, захиргааны хариуцлага ногдуулах хүсэлтээ харьяалах сум буюу сум дунд, дүүргийн шүүхэд гаргана.

Хуулийн 30 дугаар зүйлийн 30.17., 35 дугаар зүйлийн 35.6.-д заасан зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг цагдаагийн байгууллагад гаргах бөгөөд холбогдох шалгалт явуулсан цагдаагийн байгууллага үг зөрчилд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал захиргааны хариуцлага хүлээлгэх асуудлыг харьяалах сум буюу сум дунд, дүүргийн шүүхээр шийдвэрлүүлнэ.

**14.3.** Захиргааны хариуцлага ногдуулах тухай энэ хуулийн холбогдох зүйл заалтад.

**14.3.1.** Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг түүний бүрэлдэхүүнээс гаргах буюу хасахаар тусгагдсан бол энэ арга хэмжээг хуулийн 57 дугаар зүйлийн 57.4.-т зааснаар шүүх биш харин тухайн шатны сонгуулийн хороо бүрэлдэхүүнээрээ хэлэлцэж шийдвэрлэнэ.

**14.3.2.** Нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах тухай заасан бол энэ арга хэмжээг хуулийн

57 дугаар зүйлийн 57.5.-д зааснаар шүүх биш харин тойргийн хороо хянан шийдвэрлэнэ.

**14.3.3.** Шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах тухай заасан бол уг асуудлыг Шүүхийн тухай, Прокурорын байгууллагын тухай, Цагдаагийн байгууллагын тухай хуулиудад тус тус заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

**14.3.4.** Хөрөнгө улсын орлого болгохоор заасан бол уг арга хэмжээг захиргааны хариуцлага ногдуулах асуудалтай хамт биш харин хуулийн 57 дугаар зүйлийн 57.6.-д зааснаар Сонгуулийн ерөнхий хорооны гаргасан нэхэмжлэлээр шүүх иргэний хэрэг үүсгэж, хянан шийдвэрлэнэ.

**14.3.5.** Торгууль ногдуулахаас гадна дээр дурдсан арга хэмжээ авахаар хуульд заасан бол захиргааны хариуцлага ногдуулсан шийтгэвэрийг шүүх холбогдох байгууллагад нэн даруй хүргүүлнэ.

**15.** Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэхдээ шүүх Захиргааны хариуцлагын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан нөхцөл байдлыг хянаж, зөрчил гаргасан этгээдийн гэм буруу нь нотлогдсон гэж үзвэл мөн хуулийн 18 дугаар зүйлд зааснаар захиргааны шийтгэл ногдуулах тухай шийтгэвэр гаргана.

Харин зөрчил гаргасан гэх этгээдийн гэм буруу тогтоогдоогүй, эсхүл мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 4-т заасан нөхцөл байгаа бол тухайн этгээдийг хариуцлагаас чөлөөлөх тухай шүүгчийн захирамж гаргана.

**16.** Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд захиргааны шийтгэл ногдуулсан шүүхийн шийтгэвэрт гомдол гаргахад Захиргааны хариуцлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2-т заасан журмыг бус харин Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.-т заасныг баримтална.

Харин захиргааны зөрчлийг хянан шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааны талаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд Захиргааны хариуцлагын тухай хуулиас өөрөөр зохицуулаагүй тул Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан журам, үндэслэл сонгуулийн хууль тогтоомжийн зөрчлийг хянан шалгах болон хянан шийдвэрлэх ажиллагаанд нэгэн адил хамаарна.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ**
**С.БАТДЭЛГЭР**
**ТАНХИМЫН ТЭРГҮҮН**
**ЦАМАРСАЙХАН**

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5.-д заасныг тус тус удирдлага болгон **Улсын Дээд шүүхээс ТОГТООХ НЬ:**

**1.** Монгол Улсын Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн (цаашид хууль гэх) 6 дугаар зүйлийн 6.3.-т заасан **"хүндэтгэн үзэх бусад шалтгаан"** гэдэгт Сонгуулийн Ерөнхий хорооны гишүүний өөрийн үзсэнээр хорооны гишүүнээр ажиллахад саад болж буй хувь хүний ажил, амьдралын нөхцөл байдлыг хамааруулан үзнэ.

**2.** Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.-д заасан **"улс төрийн үйл ажиллагаа явуулахыг**

**хориглоно"** гэдгийг Сонгуулийн Ерөнхий хороо болон түүний Ажлын албаны үйл ажиллагаанд аль нэг нам, эвсэл, хөдөлгөөний зүгээс хутгалдан оролцох, хорооны гишүүд болон Ажлын албаны ажилтнууд албан үүргээ гүйцэтгэхдээ албан тушаалынхаа эрх мэдлийг аль нэг нам, эвсэл, хөдөлгөөний эрх ашигт нийцүүлэн ашиглах, сурталчилгаа хийх, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд оролцох, хэн нэгнийг намын гишүүнчлэлийн харьяаллаар ялгаварлан гадуурхах, улс төрийн хувьд төвийг сахих зарчмыг баримтлахгүй байх зэрэг аливаа үйлдэл, үйл ажиллагаа явуулж болохгүй гэж ойлгоно.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ**
**С.БАТДЭЛГЭР**
**ТАНХИМЫН ТЭРГҮҮН**
**ЦАМАРСАЙХАН**

 Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
 Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

 Улсын Их Хурлын Тамгын газрын  
 Хэвлэх хэсэгт хэвлэв.

 Улаанбаатар-12  
 Төрийн ордон

 265958  
 Индекс 14003

329487

Хэвлэлийн хуудас 3.5